Үүний үр дүнд өрхийн орлого нэмэгдээд зогсохгүй гэр бүл, нийгэм дэхь эмэгтэйчүүдийн байр суурь ч мөн сайжирсан. Үүнээс өмнө эмэгтэйчүүд бол зүгээр л ажилчид байлаа шүү дээ.

Нэг удаа бид тэндэхийн нэгэн төрийн бус байгууллагын сурталчилгаанд эмэгтэй хүнийг

Food for the World

For more than 20 years, the World Food Prize has rewarded individuals from any country who have made great strides in improving the quantity, quality, or availability of food for the world.

The prize represents a dream of Dr. Norman Borlaug. Known as the father of the Green Revolution, Borlaug devoted his life to increasing agriculture productivity. The methods he pioneered provided greater crop yields to feed expanding populations in the developing world. After winning the 1970 Nobel Peace Prize, Borlaug envisioned a similarly prestigious award to focus attention on agriculture and to inspire others to achievement in the field.

Since its 1986 inception, the World Food Prize, a $250,000 award, has recognized scientists and politicians from all world regions for diverse accomplishments. It is sponsored by businessman and philanthropist John Ruan and is headquartered in Des Moines, Iowa, a city in one of the great U.S. farming regions.

Dr. Gebisa Ejeta, an Ethiopian expert in plant breeding and genetics, won the Food Prize in 2009 for his development of sorghum hybrids that can survive harsh conditions. Sorghum is one of the world's principal cereal grains, a dietary mainstay in some regions. Ejeta's achievement will increase crop productivity and enhance food supplies for hundreds of millions of people in sub-Saharan Africa.

Other winners have been recognized for making unproductive land suitable for farming, developing new plant hybrids, and designing social programs to feed the poor.

Dr. Gebisa Ejeta, winner of the 2009 World Food Prize, works in field of sorghum, a primary food grain in many countries. He developed sorghum hybrids that can survive harsh conditions.

2009 оны Дэлхийн хүнсний шагналын эзэн Этиопын эрдэмтэн, доктор Г.Ежета нь олон орны хүнсний гол ургамал болох буудайн төрлөөр дагнан ажилладаг. Тэрээр цаг уурын хүндрэлтэй нөхцөлд ургах боломжтой буудайн гибридыг нээжээ.

Courtesy of Purdue University

Дэлхийн хүнс

20 гаруй жилийн туршид дэлхийн хүн амын хүнсний чанар, тоо хэмжээ болон хүртээмжийг сайжруулах салбарт өндөр амжилт гаргасан хувь хүмүүст Дэлхийн хүнсний шагналыг олгож байгаа билээ.

Энэхүү шагнал нь үндсэндээ Норман Борлаугийн мөрөөдлийн илэрхийлэл юм. Ногоон хувьсгалын эцэг хэмээгддэг Н.Борлауг нь өөрийн амьдралыг хөдөө аж ахуйн бүтээмжийг сайжруулах үйл хэрэгт зориулсан хүн юм. Түүний анхлан санаачилсан аргачлал нь хөгжиж буй дэлхийн ертөнцийн өсөн нэмэгдэж буй хүн амыг хоол хүнсээр хангахын тулд тариалангийн ургацыг ихээр нэмэгдүүлэх боломж олгосон билээ. 1970 оны Нобелийн энх тайвны шагналыг хүртсэнийхээ дараагаар Борлауг хөдөө аж ахуйн салбарт амжилт олсон бусад хүмүүсийг урамшуулах зорилгоор Нобелийн шагналын адил нэр хүнд бүхий уг шагналыг бий болгожээ.

Анхлан 1986 оноос эхэлсэн энэхүү шагналыг 250 000 ам. доллар дагалдах бөгөөд олсон амжилтыг нь үнэлэн дэлхийн бүх л орнуудын эрдэмтэд, улс төрчдөөс сонгон шалгаруулан гардуулдаг шагнал болоод байна. Энэхүү шагналыг бизнес эрхлэгч, нигүүлсэнгүй үзэлтэн Жонн Руан ивээн тэтгэдэг бөгөөд шагналын хороо нь АНУ-ын хөдөө аж ахуй, фермийн хөгжлийн томоохон төв болох Айова мужийн Дес Мойнес хотод төвлөрөн үйл ажиллагаагаа явуулж байна.

2009 оны шагналын эзнээр Этиопын эрдэмтэн, ургамлын генетикийн мэргэжилтэн, доктор Гебиса Ежета цаг агаарын хүнд нөхцөлд амьдрах чадвартай гибрид буудай бий болгосон бүтээлээрээ хүртсэн байна. Буудай нь дэлхийн зонхилох амуу тариан бүтээгдэхүүн бөгөөд зарим бүс нутгийн хүнсний голлох бүтээгдэхүүн билээ. Ежетагын бүтээл нь ургацыг нэмэгдүүлж, Сахарын Африкийн бүсийн олон зуун сая хүний хүнсний хангамжийг сайжруулахад хувь нэмрээ оруулжээ.

Энэхүү шагналыг хүртсэн бусад хүмүүс нь үржил шимгүй газрыг хөдөө аж ахуйн зориулалтаар ашиглах аргыг нээсэн, ургамлын шинэ гибридыг бий болгосон болон ядуусын хүнсний хангамжийг сайжруулах нийгмийн хөтөлбөрийг санаачилсан зэрэг амжилтаараа мөн хүртсэн байна.

Wife Does Not Work." She does everything! But unless she is bringing in a cash income, she is not regarded as working. So that's why we brought women into the picture with a low-input technology. Then once they got trained, and got the confidence, they wanted intensive production technologies for higher benefits. Now some of them are involved in fish-seed production [controlled breeding of fish as in a hatchery], which is more lucrative than fish aquaculture.

When I went to Bangladesh the aquaculture production was less than 100,000 tons. Now it is nearing 1 million tons. So it is not only increasing the production, but creating livelihoods for rural communities where there are very few opportunities for income.

Q: Political factors can also be influential in food security. Policies can encourage or discourage production, and certainly there are regimes in the world that don't place great importance on the nutrition and well-being of their people. How do you weigh the political issues contributing to hunger?

Nelson: I'm a scientist, a technologist, so that question is best posed to others. But certainly that is a major barrier in a number of areas of the world, particularly Africa. We have seen what can be done in countries where that has changed. Malawi is a good example. India is going through a renaissance as the government is beginning to focus on developing more processing techniques as a way to preserve their products and get them distributed. Governments can make a big difference.

Gupta: We are not just to look at technology, but must also look at procurement prices for farmers. When there is a bumper crop, the market price comes down and the farmers are not able to make any profit. On one side, the input costs — the fertilizer, the pesticide — are going up while on the other side, there is no guaranteed or minimum price for their commodity. It has happened in my country — when there is a bumper crop, the market price comes down and the farmers are not able to recover the expenses incurred for producing that crop.

Because of this, at times the farmers involved in food production are moving away from food crops

12 гартайгаар дүрсэлсэн байхыг харж байлаа. Нэг гараараа хүүхдээ тэвэрч, нөгөө гараараа гэрээ цэвэрлэж, бас нэг гараараа түлээ хагалж, дараагын гараараа өөр бас л нэг юм хийх зэргээр. Тэр зургийн гарчиг нь "Миний эхнэр ажил хийдэггүй" гэсэн нэртэй байсан. Гэтэл тэр эмэгтэй бүгдийг хийж байна шүү дээ! Гэхдээ эмэгтэйчүүд орлого олохгүй байгаа болохоор тэднийг зүгээр л ажилчид хэмээн үзэж байсан юм. Тийм болохоор л бид энэхүү зурган дээр дүрслэгдсэн эмэгтэйг тэрхүү бага орц бүхий технологийг хэрэглэхийг дэмжсэн юм. Сургалтад хамрагдаад, өөртөө итгэлтэй болоод ирэхээрээ тэд илүү их орлого олохуйц эрчимт технологийг эрэлхийлж эхэлсэн. Одоо тэдний зарим нь загас үрслүүлэх (загасны үржлийг хянах арга) үйлдвэрлэлд дэвшин орсон нь загас зүгээр өсгөхөөс илүү ашигтай бизнес болоод байна.

Намайг Бангладешд очиход загас үржүүлгийн нийт хэмжээ нь 100 000 тонн ч хүрэхгүй байсан бол одоо энэ тоо бараг 1 сая хүрэх гэж байна. Энэ нь зөвхөн үйлдвэрлэлийг нэмэгдүүлээд зогсохгүй, орлого олох боломж нь хязгаарлагдмал тосгоны иргэдэд амьжиргааг нь залгуулж өгсөн хэрэг юм.

Асуулт: Хүнсний баталгаат байдалд улс төрийн хүчин зүйлс ихээхэн нөлөөлж болно. Хэрэгжүүлж буй бодлого нь үйлдвэрлэлийг дэмжсэн эсвэл дэмжээгүй байхын хажуугаар дэлхийн улс гүрнүүд өөрсдийн ард иргэдийн хоол тэжээл, тэдний эрүүл ахуйн тал дээр анхаарал хандуулдаггүй жишээнүүд бий. Таны бодлоор улс төрийн асуудлууд өлсгөлөнд хэрхэн нөлөөлж байгаа гэж бодож байна вэ?

Нелсон: Би бол эрдэмтэн, технологийн мэргэжилтэн хүн тул энэ асуултыг өөр хүнд тавьбал илүү зохимжтой болох байх. Гэхдээ улс төр нь дэлхийн нилээд хэдэн бүс нутагт, ялангуяа Африк тивд ихээхэн саад учруулж буй зүйл мөн. Улс төрийн нөхцөл байдал нь эерэгээр өөрчлөгдсөн улсуудад ямар зүйл хийж, амжилтанд хүрч болдогийг бид харсан. Үүний нэг сайн жишээ бол Малави улс. Энэтхэг улс л гэхэд хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнийг хадгалан түгээх аргачлалаа хөгжүүлэн, Засгийн газрын зүгээс боловсруулах технологийг хөгжүүлэх тал дээр анхаарч ирсэний үр дүнд одоо сэргэлтийнхээ үедээ ороод байна. Үүнээс аваад үзвэл Засгийн газрууд маш их өөрчлөлтийг авчирч чадна.

Гупта: Бид нар зөвхөн технологи бус бас фермерүүдийн орц худалдан авч буй үнийг мөн авч үзэх ёстой. Ургац их авсан тохиолдолд зах зээлийн үнэ буурч фермерүүд ямар нэгэн хэмжээгээр ашиг олох боломжгүй болдог. Нэг талдаа тэдний орц болох бордоо, пестицидийн үнэ байнга өсөж байдаг ба нөгөө талыг нь харвал фермерүүдийн үйлдвэрлэж буй бүтээгдэхүүнд баталгаажсан доод үнэ гэж байдаггүй. Ийм явдал манай оронд ч тохиолдож байсан – ургац сайн авсан тохиолдолд зах зээлийн үнэ буурч,

toward the farming of commercial crops — cotton, tobacco, sugarcane, and things like that. So the government needs to ensure a minimum price for the farmers, which will take care of their well-being.

Q: The great unknown challenging global agriculture today is the effect that climate change may have as time unfolds. Let's talk about your expectations a moment. Dr. Gupta, take us back to Bangladesh, a low-lying country that will be especially vulnerable to the sea level rise that is predicted to result from climate change.

Gupta: Much work has been done with regard to the impact of climate change on crops, but not much information available as it relates to fish. Nevertheless, looking at what might happen in the oceans, there is going to be a big impact on capture fisheries. Global warming will change the fish diversity, the fish distribution, and abundance. Climate change and global warming will result in the acidification of the seawater that will have an impact on shell-bearing organisms, like the shrimp, oysters, clams, etc. To an extent, this will have an impact on aquaculture. So we are looking at developing strains of fish that are tolerant to salinity. So more needs to be done to mitigate the impact of climate change.

Q: Dr. Nelson, what's going on in the processing and preservation links of the food chain to cope with climate change?

Nelson: Climate change is putting pressure on the geneticists and plant breeders to develop varieties that can withstand droughts and reduced temperatures. That part of the production chain is critical, and without that kind of activity, I think we're looking at some major effects. On the other hand, as climate changes that means there will be differences in the production areas. That means more distribution is going to be required as we move products from one area to another, as temperatures and climates lend themselves to production.

I mentioned earlier that we are beginning to develop an international center here at Purdue. We've received some funding to do that, and the focus will be on technology and market development and reducing product losses in that part of the world where hunger threatens populations. We think there is a need to

фермерүүд тухайн ургацыг авахын тулд гаргасан зардлаа ч нөхөх бололцоогүй болсон.

Үүнээс үүдээд зарим тохиолдолд хүнсний үйлдвэрлэл эрхэлж буй фермерүүд хүнсний ургамлын тариалангаас аж үйлдвэрийн зориулалт бүхий ургамал болох хөвөн, тамхи, чихрийн нишингэ болон бусад ургамлын тариаланд шилжих болсон. Тиймээс засгийн газрууд фермерүүдийн бүтээгдэхүүний доод үнийг баталгаажуулснаар тэдний цаашдын амьжиргаанд анхаарах ёстой.

Асуулт: Дэлхийн хэмжээний тодорхойгүй бөгөөд томоохон сорилт хөдөө аж ахуйд тулгарч болох бөгөөд энэ нь цаашдаа уур амьсгалын өөрчлөлт байж болох юм. Энэ талаар та бүхний бодлыг сонсьё. Доктор Гупта та бидний нам дор газар буюу уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй далайн түвшний өсөлтөд ихээхэн өртөмтгий байж болох Бангладеш улсын талаар өөрийн бодлыг дахин ярьж өгнө үү?

Гупта: Уур амьсгалын өөрчлөлтийн тариаланд үзүүлэх нөлөөний чиглэлээр ихээхэн ажил хийгдсэн ч гэсэн энэ нь загасанд хэрхэн нөлөөлөх талаар хангалттай мэдээлэл байхгүй байна. Гэхдээ уур амьсгалын өөрчлөлтөөс хамааараад далай, тэнгист юу тохиолдож болохыг аваад үзвэл хамгийн наад зах нь загас агнуурт маш их нөлөөг үзүүлэх болно. Дэлхийн дулаарал нь загасны төрөл зүйл, загасны тархалт болон олдоцод ихээхэн нөлөөтэй. Уур амьсгалын өөрчлөлт болон дэлхийн дулаарлаас үүдээд далайн ус илүү исэлдэх ба үүний нөлөөгөөр сам хорхой, хясаа болон дун зэрэг амьтдад сөрөг нөлөө үзүүлнэ. Үүнээс үүдээд далайн гаралтай бүтээгдэхүүний үйлдвэрлэл мөн л өртөнө. Тийм болохоор бид давсархаг нөхцөлд илүү тэсвэртэй загас гарган авах чиглэлээр ажиллаж байна. Үндсэндээ уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөг бууруулахын тулд ихээхэн зүйлийг хийх шаардлага байгаа.

Асуулт: Доктор Нелсон, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицохын тулд хүнсний сүлжээний боловсруулах болон нөөшлөх салбарт ямар үйл ажиллагаа явагдаж байна вэ?

Нелсон: Уур амьсгалын өөрчлөлт нь генетикчид болон ургамлын мэргэжилтнүүдээс ган болон хүйтэнд тэсвэртэй ургамлын төрөл зүйлийг гарган авахыг шаардаж байна. Үйлдвэрлэлийн тэр хэсэг нь ихээхэн чухал бөгөөд энэхүү үйл ажиллагаагүйгээр бидэнд хэд хэдэн сөрөг нөлөө үзүүлнэ хэмээн бодож байна. Нөгөө талаар аваад үзвэл уур амьсгал өөрчлөгдөхөд үйлдвэрлэлийн салбарт өөрчлөлтүүд гарна гэсэн үг. Үүний үр дүнд хүнсний бүтээгдэхүүнийг нэг газраас нөгөөд тээвэрлэхэд агаарын температур болон уур амьсгалаас хамааараад илүү их хэмжээний бүтээгдэхүүнийг тээвэрлэн түгээх шаардлага урган гарна гэсэн үг.

Түрүүн би Пурдю их сургууль дээр олон улсын төв байгуулах талаар дурдсан. Үүнийг байгуулах зарим нэгэн санхүүжилтыг олоод байгаа ба энэхүү

bring international focus to this area of the food chain, reduce hunger, and increase food security.

Gupta: I think that improving the livelihood of the farmer has to be part of the solution too. Food production by itself will not solve the problem unless we can reduce poverty and hunger. So we are working from the perspective of creating livelihoods and improving the lives of the people in rural communities.

The opinions expressed in this interview do not necessarily reflect the views or policies of the U.S. government

---

төвийн үйл ажиллагааны гол чиглэл нь технологи болон зах зээлийг хөгжүүлэх, өлсгөлөнгийн аюултай тулгараад буй дэлхийн тэр хэсэгт үйлдвэрлэлийн алдагдлыг бууруулах чиглэлд байх болно. Миний бодлоор хүнсний сүлжээний энэ хэсэгт олон улсын анхаарлыг хандуулан, өлсгөлөнг бууруулж, хүнсний баталгаат байдлыг сайжруулах шаардлагатай байна.

Гупта: Фермерүүдийн амьжиргааг сайжруулах нь үүний шийдлийн нэг гэж би үзэж байна. Бид ядуурал, өлсгөлөнг бууруулахгүй бол хүнсний үйлдвэрлэл дангаараа энэ асуудлыг шийдэж чадахгүй. Тиймээс бид амьжиргааг бий болгох, орон нутгийн иргэдийн амьдралыг сайжруулах хэтийн төлөвтэйгээр үйл ажиллагаа явуулж байна.

(Энэхүү ярилцлагаар илэрхийлсэн үзэл бодол нь АНУ-ын Засгийн газрын үзэл бодол, бодлогыг тусгаагүй болно.)

World Food Prize Laureate 2005

Bring Fish From the Waters

Farmers everywhere have faced the same problem for millennia: They need land and rain to coax a crop from the ground.

M. Vijaya Gupta won the World Food Prize in 2005 because he found a new answer to that age-old problem. He showed poor people in South and Southeast Asia how to yield a crop from abandoned ponds, roadside ditches, and other unused bodies of water. He showed them how to recycle what was thought to be farm waste — weeds, manure, and rice bran — and use it as feed to raise a crop of fish.

With these lessons from this Indian scientist, more than 1 million poor families have increased the protein and minerals in their diets, contributing to better health and greater longevity.

Called a leader in the "blue revolution," Gupta taught poor families to convert small bodies of water into "mini-factories," producing fish for food. He, and organizations he recruited to assist, taught aquaculture techniques to poor people, training them to breed fish and increase yields for greater income. Gupta's work began with the Indian Council of Agricultural Research in the 1960s and spread over the decades to Bangladesh, Vietnam, Indonesia, and other countries.

In Bangladesh alone, fish yields increased from 304 kilograms per hectare involved in aquaculture to more than 5,000 kg per hectare. In his native India, his aquaculture techniques increased yields as much as twentyfold.

2005 оны Дэлхийн хүнсний шагналын эзэн

Уснаас загас барих нь

Дэлхийн аль ч улсын фермерүүд олон зуун жилийн туршид нэг л асуудалтай тулгарсаар ирсэн нь тэдний тариалсан ургамлыг тэтгэн ургуулах бороо байсаар ирсэн билээ.

Энэхүү олон зууны түүхтэй асуудалд тохирох шинэ шийдлийг боловсруулсан доктор М. Вижая Гупта 2005 оны Дэлхийн хүнсний шагналын эзэн болсон билээ. Тэрбээр Өмнөд болон Зүүн Өмнөд Азийн ядуучуудад, хаягдсан цөөрөм, замын хажуугийн суваг болон бусад хэрэглэгдэхгүй байгаа усны барилга байгууламжийг ашиглан хэрхэн хүнс үйлдвэрлэж болохыг зааж өгсөн юм. Түүний ажлын үр дүнд өмнө нь фермээс гарч буй хаягдал хэмээн тооцогдож байсан замаг, бууц болон будааны хивгийг эргүүлэн ашиглаж, загас үржүүлэх боломжийг нээсэн билээ.

Энэхүү Энэтхэгийн эрдэмтний заасан хичээлийг ашиглан нэг сая гаруй ядуу өрх өөрсдийн хоол тэжээлийн уураг, эрдсийн хэмжээг нэмэгдүүлж, эрүүл мэнд болон наслалтын хувьд хавьгүй сайжирсан билээ.

"Цэнхэр хувьсгалын" удирдагч хэмээн нэрлэгддэг Гупта нь тэдгээр өрхүүдэд жижиг хэмжээний усан цөөрөм болон сувгийг хүнсний зориулалтаар загас үржүүлэх бичил үйлдвэр болгох аргыг зааж өгсөн ажээ. Гупта болон түүнтэй хамтран ажиллахаар сонгогдсон байгууллагууд хамтран загас үржүүлгийн аж ахуйн аргачлалыг ядуучуудад зааснаар загас үржүүлэн орлогоо нэмэгдүүлэх боломжийг бүрдүүлжээ. Гуптагын судалгаа нь анх 1960-аад оноос Энэтхэгийн Хөдөө аж ахуйн судалгааны зөвлөл дээр эхлэн, улмаар дараагийн 10 жилийн хугацаанд Бангладеш, Вьетнам, Индонези болон бусад улсуудад түгэн дэлгэрчээ.

Зөвхөн Бангладеш улсад л гэхэд анх загас үржүүлгийн 1 га газраас 304 килограмм загас авч байсан бол одоо энэ үзүүлэлт 5 000 килограммаас даваад байна. Төрөлх нутаг болох Энэтхэгт нь түүний боловсруулсан загас үржүүлгийн аргачлал нь тухайн бизнесийн үр шимийг даруй 20 дахин өсгөөд байна.

Gupta's work has focused not on yields alone, but also on sustainability. He coordinated the International Network on Genetics in Aquaculture to encourage support for maintaining biodiversity, and has trained some 300 Asian scientists in developing sustainable production techniques.

According to the World Food Prize citation, "Dr. Gupta has been a lifelong catalyst in expanding the global reach and effectiveness of aquaculture."

Gupta has been a consultant to many organizations such as the World Bank, the Asian Development Bank, the U.S. Agency for International Development, the U.N. Development Programme, the U.N. Food and Agriculture Organization, and others. Gupta is a retired assistant director general of the World Fish Center and remains a senior research fellow at that organization, devoted to reducing poverty and hunger through the improvement of fisheries and aquaculture.

Dr. M. Vijaya Gupta (center) taught aquaculture techniques to rural people in their South Asian villages.

Courtesy of the World Food Prize Foundation

Доктор М. Вижая Гупта (төвд нь) Өмнөд Азийн тосгоны иргэдэд загас үржүүлэх аргачлал заасан билээ.

Гуптагын ажил нь зөвхөн загасны үйлдвэрлэлд бус үүний тогтвортой байдалд мөн ихээр анхаарал хандуулсан билээ. Тэрбээр Загасны аж ахуйн генетикчдийн олон улсын сүлжээний зохицуулагчаар ажиллан, биологийн төрөл зүйлийг хадгалан үлдээх үйлсийг хэрэгжүүлж, Азийн улс орнуудын 300 гаруй эрдэмтдийг тогтвортой үйлдвэрлэлийн аргачлалыг боловсруулах чиглэлээр сургалтад хамруулсан байна.

Дэлхийн хүнсний шагнал олгох мэдэгдэлд дурдсанаар "Доктор Гупта нь загас үржүүлгийн аж ахуйн үйл ажиллагаа, үр дүнг дэлхий нийтээр түгээхийг насан туршдаа хэрэгжүүлж ирлээ" хэмээн дурдсан байна. Гупта нь Дэлхийн банк, Азийн хөгжлийн банк, АНУ-ын Олон улсын хөгжлийн агентлаг, НҮБ-ийн Хөгжлийн хөтөлбөр болон Олон улсын хүнс, хөдөө аж ахуйн байгууллага зэрэг олон байгууллагын зөвлөх хийдэг. Гупта нь одоо тэтгэвэрт гарсан профессор бөгөөд үүний хажуугаар Дэлхийн загасны төвийн захирлаар ажиллан загас үржүүлэг болон усны аж ахуйг хөгжүүлсэнээр ядуурал, өлсгөлөнг бууруулах зорилт тавин ажиллаж байна.

World Food Prize Laureate 2007

Fresh From Farm to Plate

If you've ever had soup or milk or juice from a box, then you know the work that won the World Food Prize in 2007. Aseptic (sanitary) food processing technologies allow consumers in developed nations to toss a box of juice in a picnic basket. But these methods also preserve crops, prevent spoilage, and increase the availability of safe and nutritious foods.

Dr. Philip E. Nelson developed "innovative breakthrough technologies, which have revolutionized the food industry … in the area of large-scale storage and transportation of fresh fruit and vegetables," according to the World Food Prize citation. Aseptic food processing allows juices and other liquid foodstuffs to be packaged and shipped around the world in mass quantities.

Here's how it works. Once plant or animal products are made into food — fruits into juice, for instance — Nelson's process allows sterilization of the food and the package, and the transfer of the food into the package. The output is a safe, stable product that can be easily transported without refrigeration, and can remain in storage for considerable periods of time before being shipped to market or being used by the consumer.

In the process, food is passed through a thin pipe in which it is rapidly heated to kill any pathogens, then quickly cooled to maintain the freshness of the food. Nelson began his innovative work while on the faculty at Purdue University in Indiana. The process already had been developed, but Nelson found ways to apply it on a large scale, as large as the 500,000-gallon containers used in intercontinental shipping.

2007 оны Дэлхийн хүнсний шагналын эзэн

Тариан талбайгаас тавган дээр шинээрээ

Хэрэв та хэзээ нэгэн цагт хайрцагт савласан жүүс, сүү ууж байсан бол та 2007 оны Дэлхийн хүнсний шагналыг хүртсэн бүтээлийг мэднэ гэсэн үг. Хүнсний ариутган боловсруулах технологи нь хөгжиж буй орны хэрэглэгчдэд аялалаар явахдаа тусгайлан савласан жүүсийг сагсандаа авч явах боломжийг олгосон билээ. Гэхдээ энэхүү аргаар мөн үр тариаг савлаж, муудахаас сэргийлэн, аюулгүй, тэжээллэг хүнсний олдоцыг бас нэмэгдүүлж чадсан юм.

Доктор Филип И. Нелсон нь"жимс, ногоог шинээр нь их хэмжээгээр нөөшлөх болон тээвэрлэх боломжийг олгон, хүнсний аж үйлдвэрийн салбарт хувьсгал гаргасан шинэ технологийг нэвтрүүлсэн" хэмээн Дэлхийн хүнсний шагналын мэдэгдэлд дурдсан байлаа. Хүнсний ариутган боловсруулалт нь жүүс болон бусад шингэн хүнсний бүтээгдэхүүнийг их хэмжээгээр хадгалан, савлаж дэлхий даяар түгээх боломжийг олгосон юм.

Энэхүү аргачлал хэрхэн явагддаг болохыг тайлбарлая. Ургамлын болон амьтны гаралтай бүтээгдэхүүнийг хүнс болгон боловсруулсаны дараагаар, жишээ нь жимсийг шахан жүүс үйлдвэрлэсний дараа Нелсоны боловсруулсан аргачлалаар хүнсийг ариутган, савлах буюу хүнсний бүтээгдэхүүнийг саванд шилжүүлнэ. Энэхүү бүтээгдэхүүн нь аюулгүй, тогтвортой бүтээгдэхүүн болох бөгөөд үүнийг хөргөлтгүйгээр хол замд удаан хугацаагаар тээвэрлэн, зах зээлд хүргэж, хэрэглэгчдийн гар дээр тавих хүртэл аюулгүй хадгалах боломжтой болно.

Энэхүү технологийн процессын үеэр хүнсний бүтээгдэхүүн нь нарийн хоолойгоор дамжих ба энэ үеэр тун хурдан хугацаанд халаан, хүнсэнд агуулагдаж буй патогенийг устгах ба дараагаар нь маш хурдан хугацаанд хөргөн, хүнсний бүтээгдэхүүний цэвэр байдлыг хангадаг ажээ. Энэхүү дэвшилтэт аргын талаарх судалгаагаа Нелсон Индиана мужид байрлах Пурдю их сургуульд ажиллаж байх үедээ судлаж эхэлжээ. Хэдийгээр энэхүү процесс нь өмнө нь боловсрогдсон байсан ч гэсэн Нелсон үүнийг их

Nelson's techniques have benefitted developing world countries where crop spoilage can consume as much as 50 percent of yields in some places. Aseptic processing has also been a key technology in the expansion of feeding and nutrition programs in the developing world and in providing stores of products available for transport to regions stricken with disaster, such as the 2004 tsunami in the Indian Ocean.

Nelson is the Scholle Chair Professor of Food Processing in the Department of Food Sciences at Purdue University in West Lafayette, Indiana.

Courtesy of the World Food Prize Foundation



Dr. Philip Nelson won the World Food Prize for his development of packaging methods that allow safe and sanitary transport and storage of liquid foods and juices.

Доктор Филип И. Нелсон нь Дэлхийн хүнсний шагналыг шингэн хүнс болон жүүсийг аюулгүй, бохирдолгүй хадгалан, тээвэрлэх боломж олгосон савалгааны аргачлалаараа хүртсэн билээ.

хэмжээний бүтээгдэхүүнд хэрэглэх аргыг нээн олж, үүнийг ашиглан 500 000 галлон хүртэлх багтаамжтай саванд тив хооронд тээвэрлэхүйц бүтээгдэхүүнийг боловсруулах боломжийг нээжээ.

Нелсоны уг аргачлал хүнсний бүтээгдэхүүнийх нь бараг 50% нь муудан хаягдаж буй зарим хөгжиж буй орнуудад ихээхэн ашиг тустай зүйл болсон юм. Хүнсний ариутган боловсруулалт нь хөгжиж буй орнуудад хүнс тэжээлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх, мөн 2004 онд Энэтхэгийн далайд болсон цунами зэрэг байгалийн гамшигийн үеэр хүнсний бүтээгдэхүүнийг хадгалан, тээвэрлэхэд ихээхэн чухал аргачлал болсон билээ.

Нелсон нь одоо Индиана муж улсын Вест Лафайет хот дахь Пурдю их сургуулийн Хүнсний шинжлэх ухааны тэнхимийн Хүнсний технологийн багийн профессороор ажилладаг.

U.S. Food Policy Aims for “Transformational Change”

The Obama administration initiative to improve food security worldwide

“The true sign of success is not whether we’re the source of perpetual aid that helps people scrape by, it’s whether we are partners in building the capacity for transformational change.”

President Obama in Ghana, 2009

Secretary of State Hillary Clinton and Secretary of Agriculture Tom Vilsack announced details of the U.S. Food Security Initiative on World Food Day in October 2009.

The goals are:

- Reduce hunger sustainably,
- Raise the incomes of the rural poor,
- Reduce the number of children suffering from under-nutrition.

Five key principles guide the initiative:

- The United States will work with partner countries to create and implement plans.

АНУ-ын хүнсний бодлого "Шилжилтийн өөрчлөлтөд" чиглэж байна

Обамагын засаг захиргаа Дэлхийн хүнсний баталгаат байдлын санаачилгын хүрээнд ахиц гаргаж байна

“Амжилтын жинхэнэ шинж тэмдэг нь бид хүмүүсийг хүнд нөхцөлөөс гарахад нь тусламж үзүүлж буй голлох эх үүсвэр болох явдал бус, харин бид шилжилтийн өөрчлөлтийг хийх чадавхийг бэхжүүлэх түншүүд болж буй явдал юм”

Ерөнхийлөгч Обама (2009 онд Гана улсад хэлсэн үгнээс)

Төрийн нарийн бичгийн дарга Хиллари Клинтон болон Хөдөө аж ахуйн сайд Том Вилсак нар 2009 оны 10 дугаар сард Дэлхийн хүнсний өдрөөр АНУ-ын Хүнсний аюулгүй байдлын санаачилгын талаарх доорх мэдээллийг зарлалаа.

Энэхүү санаачилгын зорилго нь:

- Өлсгөлөнг тогтвортойгоор бууруулах,
- Хөдөөгийн ядуучуудын орлогыг нэмэгдүүлэх,
- Тэжээллэгийн дутагдлаас зовон шаналж буй хүүхдүүдийн тоог бууруулах.

Энэхүү санаачилгыг таван гол зарчимд нийцүүлэн хэрэгжүүлэх ба үүнд:

- АНУ нь түнш орнуудтай хамтран төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэх,
- Санаачилгын хүрээнд фермерүүдийг дэмжихэд шаардлагатай аргачлал, тэдний ур чадвар болон үйл ажиллагаанд хөрөнгө оруулах,
- Санаачилгын хүрээнд орон нутгийн болон бүс нутгийн хүчин чармайлтыг нягт хамтран зохицуулах,

• The initiative will invest in the tools necessary to support farmers, their skills, and perseverance.
• The initiative will coordinate closely with local and regional efforts.
• The initiative will support the multilateral institutions combating world hunger.
• The initiative will be a long-term and accountable U.S. commitment.

In fulfilling the initiative, scientists and experts at the U.S. Department of Agriculture will:

• Apply themselves to improving the nutritional and productive value of crops around the globe;
• Help partners resolve technical challenges related to irrigation, crop improvement, pest eradication, and other problems;
• Help other nations train their future agricultural leaders.

U.S. officials emphasize that food security is important in achieving economic, environmental, and national security.

© AP Images/Saurabh Das

The U.N. Food and Agriculture Organization reports that one in nearly every six people lacks adequate food to live an active and healthy life.

НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллагын тайланд дурдсанаар зургаан хүн бүрийн нэгд идэвхтэй, эрүүл амьдралыг нь хангах хүнс тэжээл дутагдалтай байдаг байна.

• Санаачилгын хүрээнд дэлхийн хэмжээнд өлсгөлөнтэй тэмцэж буй олон талт байгууллагуудыг дэмжих,
• Санаачилга нь АНУ-ын урт хугацааны, хариуцлагатай үйл ажиллагаа байх.

Санаачилгыг хэрэгжүүлэхэд АНУ-ын Хөдөө аж ахуйн яамны эрдэмтэд, мэргэжилтнүүд доорх үйл ажиллагааг хэрэгжүүлэх ба үүнд:

• Дэлхийн хэмжээнд хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний тэжээллэг болон бүтээлч үнэлэмжийг нэмэгдүүлэх талаар ажиллах,
• Усалгаа, тариалангийн сайжруулалт, хортон шавьж устгах болон бусад тулгараад буй асуудлуудаар түншүүддээ техникийн туслалцаа үзүүлэх,
• Бусад улсуудад өөрсдийн ирээдүйн хөдөө аж ахуйн манлайлагч нарыг сурган бэлтгэхэд нь туслалцаа үзүүлэх.

АНУ-ын албаны хүмүүс эдийн засаг, байгаль орчин болон үндэсний аюулгүй байдлыг хангахад хүнсний баталгаат байдал ихээхэн чухал болохыг цохон дурдсан билээ.

Life on the Land

Anthropologists have long believed that agriculture provided the seeds from which civilization grew. When early humans realized how they might nurture the growth of food plants, rather than simply forage for their fruit, many gave up a nomadic life to tend the same land each year. Scholars of early human civilization believe that this settled lifestyle, and the cultivation of crops, led to a need to barter or sell the harvest, and so came markets, settlements, and towns.

Agriculture has served as a force to build communities throughout human history — the shared work of the fields, the shared bounty and hardship, the community celebration of the harvest.

In many countries, rural populations have dwindled as farming has become more mechanized and young people seek opportunities in the cities. The dominance of farming as a way of life has diminished in industrialized countries. World demographers calculate that recent years marked a turning point where more people live in cities than in the country. Still, a shared life on the land remains a bond for families and communities in many places. What they produce is the food, fiber, and fuel of the entire population, nurturing and sustaining us all each day.

Газар түшсэн амьдрал

Антропологич нар олон жилийн туршид хөдөө аж ахуй л өнөөгийн амьдралын үрийг тарьсан хэмээн итгэсээр ирсэн билээ. Эртний хүн төрөлхтөн ургамлын өсөлтийг хэрхэн ашиглаж болохыг ажигласнаар зөвхөн жимсийг түүж авахаас өөр арга байгааг мэдрэн, улмаар өөрсдийн нүүдэлчин амьдралаа орхин тухайн газрыг байнга тордон, үр жимсийг нь хүртэхээр суурьшиж эхэлжээ. Эртний хүн төрөлхтний соёл иргэншлийг судлаач эрдэмтэд энэхүү суурин амьдрал, тариалан эрхлэх болсон зэрэг нь өөрсдийн ургацыг борлуулах болон бусад хэрэгтэй бүтээгдэхүүнээр солилцох хэрэгцээг үүсгэн, улмаар зах, суурин газар, хотууд үүссэн хэмээн итгэдэг.

Хөдөө аж ахуй нь хүн төрөлхтний түүхийн туршид нийгэм олон нийтийг бий болгох хүч болж байсан ба тариан талбай дээр хамтран ажиллах, баяр гунигаа хамтдаа хуваалцах, арвин их ургац авсанаа нийтээр тэмдэглэх зэргээр үүний үр үндэсийг үүсгэжээ.

Олон оронд фермерийн аж ахуй илүү механикжиж, улмаар зах зээл хумигдахад, хөдөөгийн иргэдийн тоо буурч, залуус шинэ боломжийг эрэлхийлэн хот суурин газар руу зүглэх болжээ. Аж үйлдвэр өндөр хөгжсөн оронд фермерийн аж ахуйг амьдралын гол хүчин зүйл хэмээн үзэх үзэл харьцангүй багасчээ. Дэлхийн хүн ам зүйн нөхцөл байдлаас харвал хот суурин газруудад хөдөөгийнхөөс илүү олон хүн ажиллаж амьдардаг үзүүлэлт эргэлтийн байдалтай байна. Олон бүс нутагт газарт түшиглэсэн өрх, нийгэм олон нийтийн амьжиргааны хэлбэр үргэлжилсэн хэвээр л байна. Тэд дэлхийн хүн амын хэрэглээний хүнс, ноос ноолуур болон түлшийг хийж бидний амьдральд санаа тавьж, тогтвортой байдлыг хангаж байна.



© AP Images/Anupam Nath

An Indian farmer goes to work in a paddy field near Gauhati, India.
Энэтхэг фермер Гаухати муж дахь намгархаг газраар ажилдаа явж байгаа нь.

Life … Land
Амьдрал … Газар

© AP Images/Geoff Caddick PA Wire

This roof garden atop London's Trafalgar Hotel is part of an effort to create new gardens across the city where citizens may grow food for themselves or their communities. The Capital Growth scheme has provided both financial support and coaching to create 100 gardens around the city.

Лондон хотын Трафальгар зочид буудлын дээвэр дээрх энэхүү цэцэрлэг нь иргэд өөрсдийн болон нийтийн хэрэгцээнд хүнсний ногоо тарьж ургуулах шинэ цэцэрлэгийг хотдоо бий болгох үйл ажиллагааны хүрээнд байгуулагджээ. Нийслэл хотод ногоо тариалах энэхүү хөдөлгөөний хүрээнд 100 цэцэрлэг бий болгож, тэднийг сургалт болон санхүүжилтаар хангажээ.

© AP Images/Pavel Rahman

Village women separate dust from rice grain, the most important crop of Bangladesh. About 45 percent of the population works in agriculture. Seasonal monsoons flood nearly a third of the country each year, frequently destroying crops and causing extensive damage to agricultural infrastructure.

Тосгоны эмэгтэйчүүд Бангладешийн хамгийн чухал таримал ургамал болох цагаан будааны тоосыг цэвэрлэж байгаа нь. Тус улсын хүн амын 45 орчим хувь нь хөдөө аж ахуйд ажиллаж байна. Жил тутамд бүтэн улирлын туршид үргэлжилдэг борооны улирал нь энэ улсын нутаг дэвсгэрийн бараг гуравны нэг хэсгийг үерт автуулдаг бөгөөд үүний улмаас ургац устах болон хөдөө аж ахуйн дэд бүтцэд ихээхэн хохирол учирч байна.

Life … Land
Амьдрал ... Газар

© AP Images/Rajesh Kumar Singh

Farm workers carry cucumbers to market in Allahabad, India. Agriculture employs more than half of India's population, although it comprises less than 20 percent of the economy.

Энэтхэгийн Аллахабад мужийн фермийн ажилчид өөрсдийн тарьж ургуулсан өргөст хэмхийг зах руу зөөж байгаа нь. Энэтхэгийн хүн амын талаас илүү хувь нь хөдөө аж ахуйн салбарт ажилладаг боловч тус салбар нь улсынхаа эдийн засгийн 20 хүрэхгүй хувийг л эзэлдэг байна.

© AP Images/Alex Brandon

First lady Michelle Obama invited elementary school children to the White House in 2009 to help plant a vegetable garden. She also is leading a campaign to combat childhood obesity and to promote the health benefits of eating fresh foods.

Тэргүүн хатагтай Мишель Обама 2009 онд дунд сургуулийн сурагчдыг Цагаан ордонд урьж, хүнсний ногооны цэцэрлэг байгуулахад туслалцуулжээ. Тэрээр мөн хүүхдийн таргалалттай тэмцэх, цэвэр хүнс хэрэглэхийн эрүүл мэндийн ач холбогдлыг сурталчлах кампанит ажлыг удирдаж байна.

© AP Images/Mohammad Abu Ghosh

Women farmers share their lunch in a field in southern Jordan. Almost 50 percent of farm workers in many countries are women, and they play a vital role across the range of agricultural systems including production, processing, and marketing of farm products.

Өмнөд Иордан дахь тариалангийн талбайн эмэгтэй фермерүүд өдрийн хоолоо хуваан идэцгээж байгаа нь. Олон оронд фермийн ажилчдын 50% нь эмэгтэйчүүд байдаг бөгөөд тэд фермийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл болон зах зээлд борлуулах зэрэг хөдөө аж ахуйн олон салбарт ихээхэн чухал үүргийг гүйцэтгэдэг.

Life … Land
Амьдрал ... Газар

John Eastcott & Yva Momatiuk/National Geographic Stock

© AP Images/Paulo Santos

A family in Poland farms at the foothills of the Tatra Mountains. About 60 percent of the nation's land is devoted to agriculture and the country is a significant exporter of bacon, ham,and frozen fruits and vegetables.

Тара уулын бэл дэхь ферм дээрээ ажиллаж буй Польш гэр бүл. Энэхүү улсын нийт газар нутгийн 60% нь хөдөө аж ахуйд ашигдагддаг ба Польш улс нь гахайн утсан мах, гахайн мах болон хөлдөөсөн жимс, ногооны томоохон экспортлогч болоод байна.

A farmer works in his cocoa plantation in Brazil's Para state. Brazil is a major food supplier to international markets, with the agricultural and food sectors comprising 28 percent of the country's gross domestic product. Economic and trade stability and regulatory reforms have encouraged agriculture and boosted the nation's output in recent years. Brazil is an important producer of sugar, ethanol, beef, poultry meat, and coffee.

Бразилын Пара мужийн фермер какаоны тариалан дээрээ ажиллаж байгаа нь. Бразил нь олон улсын зах зээл дээрх хүнсний томоохон нийлүүлэгч бөгөөд тус улсын хөдөө аж ахуй, хүнсний салбар нь дотоодын нийт бүтээгдэхүүнийх нь 28%-ийг эзэлдэг. Эдийн засаг, худалдааны тогтвортой байдал, зохицуулалтын шинэтгэлийн үр дүнд хөдөө аж ахуйн салбарт ихээхэн амжилт олж сүүлийн жилүүдэд нийт үйлдвэрлэл нь нэмэгдсээр байна. Бразил нь чихрийн нишингэ, этанол, үхрийн мах, шувууны аж ахуйн бүтээгдэхүүн болон кофены ихээхэн чухал үйлдвэрлэгч билээ.

Life … Land
Амьдрал ... Газар

Chinese farmers operate a reaping machine, harvesting wheat in Jiangsu province. China is the world's biggest grain producer, and aims further to boost production to feed its population, approaching 1.4 billion, the largest in the world.

Хятадын Жиансу мужийн фермерүүд улаан буудай хурааж байгаа нь. Хятад улс нь дэлхийн улаан буудайн хамгийн том үйлдвэрлэгч бөгөөд цаашид 1.4 тэрбумд дөхөн очиж буй өөрийн хүн амын хэрэгцээг хангах зорилгоор үйлдвэрлэлээ улам нэмэгдүүлэн, дэлхийн тэргүүлэх хэмжээнд очихоор төлөвлөж байна.

© AP Images/Qiu Wenshan/Imaginechina

Farmers carry bundles of straw to market in Agartala, India. The straw is used as cattle feed in India. Indian farmers lead the world in production of lemons, limes, and other tropical fruits.

Фермерүүд боодолтой сүрлийг Энэтхэгийн Агартала хотын зах руу зөөж байгаа нь. Энэтхэгт сүрлийг үхрийн тэжээлд өргөн ашиглаж байна. Энэтхэгийн фермерүүд дэлхийн хэмжээнд нимбэг болон бусад халуун орны жимсний үйлдвэрлэлээрээ дэлхийд тэргүүлж байна.

© AP Images/Ramakanta Dey

Ted Spiegel/National Geographic Stock

Young men harvest squash on a farm in New Brunswick, Canada. Agriculture comprises only 2 percent of the Canadian economy, but its vast land expanses allow this North American country to be the world's second largest producer of rapeseed, grown for animal feed; the vegetable oil, Canola; and biofuel.

Канадын Нью Брюнсвик дахь талбайгаас хулуу хурааж буй залуу фермер. Хөдөө аж ахуй нь Канадын эдийн засгийн 2%-ийг эзэлдэг хэдий ч өргөн уудам нутагтай Хойд Америкийн энэ улс нь малын тэжээлийн ургамал болох рапс, хүнсний тосны ургамал, канола болон био түлшний тариалалтаар дэлхийд хоёрдугаарт бичигдэж байна.

Life … Land
Амьдрал ... Газар

© Russ Munn/AgStock Images/CORBIS

A farmer and his wife survey their soybean crop in the U.S. state of Iowa. This couple owns one of more than 88,000 farms in the Midwestern state.

АНУ-ын Айова муж дахь фермер гэр бүл шар буурцгийн тариалангаа шалгаж байгаа нь. Энэ гэр бүл Баруун дундад мужуудад байдаг 88 000 фермийн нэгийг эзэмшдэг.

© AP Images/The Roanoke Times/ Kyle Green

Diverse people meet in community gardens, such as this one in Roanoke, Virginia. Forty gardeners share a space in a working class neighborhood. Burundian refugee Shemezimana Ezekiel meets garden founder Mark Powell (center) and Judy Powell.

Виржиниа мужийн Роанок дахь энэхүү олон нийтийн цэцэрлэгийн адил газруудад олон хүмүүс бие биетэйгээ уулздаг. Энэхүү ажилчдын хороололд амьдардаг 40 хүн энэхүү цэцэрлэгийн талбайг хуваан ашигладаг юм. Бурунди улсаас ирсэн дүрвэгч Шемезимана Эзекейл цэцэрлэгийг үндэслэгч Марк Повель (дунд нь) болон Жуди Повель нартай уулзаж байгаа нь.

© AP Images/Mohammad Abu Ghosh

A shepherd milks sheep, a product that ranks fourth in Jordan's overall agricultural output. Although agriculture remains economically important, its share of Jordanian gross national product has been in decline as the industrial and service sectors of the economy have expanded.

Иорданы хоньчин улсынхаа хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний дөрөв дэх гол бүтээгдэхүүн болох хонины сүү сааж байгаа нь. Хэдийгээр хөдөө аж ахуй нь эдийн засгийн хувьд чухал хэвээр буй ч гэсэн энэхүү аж үйлдвэр болон үйлчилгээний салбарын өсөлтөөс хамааран хөдөө аж ахуйн салбарын дотоодын нийт бүтээгдэхүүнд ноогдох хувь хэмжээ жилээс жилд буурсаар байна.

Life … Land
Амьдрал ... Газар

© AP Images/Seth Perlman

© AP Images/Greg Baker

A farmer from the U.S. state of Illinois handles soybean seeds in a bin attached to planting machinery that will sow multiple seed rows. This farmer grows corn and soybeans on his 525 hectares. Nearly 80 percent of the state's area is agricultural land, divided into more than 75,000 farms. Marketing of soybeans accounts for about one third of the state's $9 billion annual agricultural production.

АНУ-ын Иллинойс мужийн фермер шар буурцагны үрийг олон эгнээгээр зэрэг суулгах зориулалт бүхий машинд суурилуулсан үрлэгч хайрцаган дахь үрийг үзэж байгаа нь. Энэ фермер нь өөрийн эзэмшлийн 525 га газарт эрдэнэ шиш, шар буурцаг тариалдаг. Тус мужийн газар нутгийн бараг 80% нь хөдөө аж ахуйн зориулалтаар ашиглагдаж буй бөгөөд эдгээрийг 75 000 гаруй фермер эзэмшиж байна. Шар буурцаг нь уг мужийн жилийн 9 тэрбум ам. долларын орлого бүхий хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн гуравны нэгийг эзэлдэг.

A Chinese woman in Guangxi province waters her vegetables, using water carried by buckets from the lake in the background. China is a major producer of a variety of vegetables such as carrots, turnips, eggplant, squash, and onions.

Хятадын Гуанши мужийн эмэгтэй ойролцоох нуураас хувингаар зөөн авчирсан усаараа ногооны талбайгаа усалж байгаа нь. Хятад улс нь лууван, манжин, хаш, хулуу болон сонгино зэрэг олон төрлийн хүнсний ногооны голлох үйлдвэрлэгч билээ.

The Borlaug Legacy: A New Paradigm for Agricultural Research

Roger Beachy

Norman Borlaug applied the latest technological and scientific advances to the age-old goal of feeding the world's people and revolutionized food production. The U.S. Department of Agriculture (USDA) aims to continue his work and achieve equally transformative change for the health of global society.

Roger Beachy is chief scientist and director of the National Institute of Food and Agriculture in the U.S. Department of Agriculture. Prior to his 2009 appointment, Beachy was founding president of the Donald Danforth Science Plant Center, which is dedicated to improving the human condition through plant science.

The opportunity to truly transform a scientific field occurs at best once a generation. The recently deceased Norman Borlaug seized one such opportunity. In a career spanning four decades, but especially during the 1960s, Borlaug revolutionized production of wheat, rice, and maize — the staple crops that feed most of the world.

The Nobel Peace Prize was only one among the many honors bestowed on Borlaug for his contributions to the "Green Revolution." At his death in 2009, he was hailed by developing countries as one of America's great heroes for his many contributions to global food security. The president and prime minister of India, to offer but one example, called

Борлаугийн үлдээсэн өв: Хөдөө аж ахуйн салбарын судалгааны шинэ загвар, аргачлал

Рожер Бийчи

Норман Борлауг нь хамгийн сүүлийн үеийн технологи, шинжлэх ухааны дэвшилийг олон жилийн настай хүн төрөлхтнийг хоол хүнсээр хангах зорилгод бүтээлчээр ашиглан, хүнс үйлдвэрлэлд хувьсгал гаргасан юм. АНУ-ын Хөдөө аж ахуйн яам түүний ажлыг үргэлжлүүлэн дэлхий нийтийн эрүүл мэндийг тэгш хамарсан өөрчлөлт шилжилтийг хийхээр хичээж байна.

Рожер Бийчи нь АНУ-ын Хөдөө аж ахуйн яамны Үндэсний хүнс, хөдөө аж ахуйн хүрээлэнгийн ерөнхий судлаач, захирлаар ажилладаг. 2009 онд энэхүү албан тушаалд томилогдохоосоо өмнө Бийчи нь ургамлын шинжлэх ухааны ололтыг ашиглан хүн төрөлхтний нөхцөл байдлыг сайжруулах зорилго бүхий Доналд Данфортын шинжлэх ухаан, ургамлын төвийг үүсгэн байгуулагч ерөнхийлөгчөөр ажиллаж байлаа.

Шинжлэх ухааны салбарт гайхалтай нээлт хийх боломж магадгүй нэгэн үеийн турш ганц л тохиож болно. Саяхан хорвоогийн мөнх бусыг үзүүлсэн Норман Борлауг энэхүү боломжийг ашиглаж чадсан нэгэн. 40 гаруй жилийн хөдөлмөрийнхөө үр дүнд, ялангуяа 1960-аад оны үеэр Борлауг нь дэлхийн дийлэнх хэсгийн хүнсний голлох бүтээгдэхүүн болох улаан буудай, будаа болон эрдэнэ шишийн үйлдвэрлэлд хувьсгал хийсэн билээ.

Түүний хүртсэн Нобелийн энх тайвны шагнал нь Борлаугийн "Ногоон хувьсгал"-д оруулсан хувь нэмрийг үнэлэн олгосон олон шагналын зөвхөн нэг нь байсан юм. 2009 онд нас нөхцөх үедээ тэрбээр дэлхий нийтийн хүнсний баталгаат байдалд оруулсан олон хувь нэмрээрээ хөгжиж буй орнуудын дунд Америкийн агуу баатрын дүрээр мөнхөрсөн байлаа. Энэтхэгийн Ерөнхийлөгч болон Ерөнхий сайд нар Борлаугийн амьдрал, бүтээлийг "хувь хүний агуу сонирхол,

Borlaug's life and achievement "testimony to the far-reaching contribution that one man's towering intellect, persistence, and scientific vision can make to human peace and progress." Today, Borlaug's insights inform an intense effort to harness the latest scientific advances to the oldest of goals: assuring adequate, nutritious food for all the world's citizens.

Borlaug 's Work

Borlaug's early work in Mexico aimed to develop and introduce disease-resistant wheat strains. It was so hampered by inadequate resources, poor equipment, and the lack of trained scientists that Borlaug thought seriously about leaving the project.

Dr. Norman Borlaug (standing, left) introduced planting techniques to increase yields and feed greater numbers of people. He talks with other agricultural researchers in Mexico in 1983.

© Ted Streshinsky/CORBIS

Норман Борлауг (зүүн гар талд зогсож буй) ургамлын ургацыг нэмэгдүүлэн, олон тооны хүмүүсийг хоол хүнсээр хангах аргачлалыг боловсруулсан билээ. Тэрээр хөдөө аж ахуйн мэргэжилтнүүдтэй 1983 онд Мексикт уулзаж байгаа нь.

хөдөлмөр, оюун ухаан болон шинжлэх ухааны холын хараагаар хүн төрөлхтний энх тайван, хөгжил дэвшлийн төлөө оруулсан хувь нэмрийн бодит гэрч" хэмээн нэрлэж байсан билээ. Өнөөдөр түүний үлдээсэн шинжлэх ухааны шинэ дэвшлүүдийг өнө эртний зорилгууд болох хангалттай, тэжээллэг хоол хүнсээр дэлхийн иргэдийг хангах зорилгод чиглүүлэх эрчимтэй үйл ажиллагааг явуулах хэрэгтэйг харуулж байна.

Борлаугийн бүтээл

Борлаугийн анхан үеийн хийж байсан ажил нь Мексикд өвчинд тэсвэртэй улаан буудай гарган авах чиглэлтэй байжээ. Гэвч энэхүү чармайлт нь нөөц эх үүсвэр хангалтгүй, тоног төхөөрөмж муутай, бэлтгэгдсэн мэргэжилтнүүд дутмаг зэргээс хамааraад амжилтад хүрээгүй тул Борлауг ч гэсэн тухайн төслийг орхихоор шийдээд байжээ.

His new idea — to shuttle wheat seeds to new locations where altitude and temperature differences would allow a second growing season — ran afoul of conventional botanical wisdom. But he persevered. Risking his career and reputation, he pursued the new double season regimen. He held fast to a tightly focused agenda, developing new strains with high potential for quick and tangible outcomes, scaled up his work to include many geographic areas and environments, and kept the end goal — reducing hunger by improving wheat yield — fixed firmly in mind.

By 1963, 95 percent of Mexico's wheat harvest derived from Borlaug's improved varieties — and the harvest was six times higher than in 1944, when he first began his work there. Mexico had not only become self-sufficient in wheat production, it was a net wheat exporter.

Borlaug's success in boosting Mexican yields repeated itself over six decades of incredible scientific advances. These saved hundreds of millions throughout the developing world from starvation and malnutrition. His work touched small- and large-scale farmers alike. It is hard to imagine a staple crop anywhere in the world where Borlaug's tools, techniques, or actual hands-on research have not led to substantial improvements in production, nutritional quality, or resilience of crops to pests, disease, or adverse climatic conditions.

Borlaug's sweeping transformation of global plant cultivation is truly a legacy to admire. But for those of us who manage scientific endeavors, he left another enduring legacy: He was not afraid to take risks. He focused on solving large-scale problems with similarly large-scale research, and he worked on projects where the payoff in food security was tangible and immediate.

Borlaug proved that science and technology could improve the well-being of people across the globe. In his last years, he realized that future challenges demanded new tools, new strategies, and new intellect if science is to improve the human condition further. In the agriculture community, we can put this legacy, and this insight, into action.

Түүнд төрсөн шинэ санаа болох улаан буудайн үрийг байрлал (өндөр) болон температурын зөрөө ихтэй газарт жилдээ хоёр удаа сэлгэн тариалах талаар байсан хэдий ч ургамал зүйн энгийн ойлголтын хүрээнд хүршгүй зүйл байлаа. Гэхдээ л тэрбээр тэсч үлдэн өөрийн албан тушаал болон нэр хүндийг эрсдэлд оруулан байж ажлаа үргэлжлүүлсэн. Тэрээр хурдан хугацаанд, маш нарийн хуваарийн дагуу ажиллаж өндөр ургац өгөх буудайн шинэ төрлийг бий болгож, өөрийн хийсэн ажлыг газар зүйн болон орчны хувьд өөр өргөн хэмжээний бүс нутагт түгээн дэлгэрүүлэх бүхий л үйл явцынхаа туршид зөвхөн өөрийн эцсийн зорилго болох улаан буудайн гарцыг нэмэгдүүлснээр өлсгөлөнг бууруулах хэмээн зорилгоо чанд даган мөрдөж байлаа.

1963 он гэхэд Борлаугийн гаргасан шинэ төрлийг нийт тариалалтынхаа 95% нь хэрэглэн тариалсан Мексикийн улаан буудайн ургац нь 1944 оныхтой харьцуулбал буюу Борлауг Мексикд анхлан ажиллаж эхэлсэн тэр үеийнхтэй харьцуулбал 6 дахин илүү байлаа. Үүний үндсэн дээр Мексик улс нь улаан буудайн үйлдвэрлэлээр өөрийгөө бүрэн хангаад зогсохгүй улаан буудай экспортлогч болсон билээ.

Мексикийн улаан буудайн ургацыг нэмэгдүүлсэн энэхүү амжилт нь 60 гаруй жил давтагдсан юм. Түүний гаргасан шинжлэх ухааны нээлт нь хөгжиж буй орнуудын олон сая хүнийг өлсгөлөн, тэжээлийн дутагдлаас аварсан юм. Түүний бүтээл том болон жижиг фермерүүдэд ч гэсэн ижил үр дүнг үзүүлсэн билээ. Борлаугийн боловсруулсан арга, техник, судалгааны арвин баялаг баримт нь үйлдвэрлэлийг ихээр нэмэгдүүлээгүй, тэжээллэгийн чанарыг сайжруулаагүй, хортон болон өвчинд ургамал тэсвэртэй болоогүй, уур амьсгалын нөхцөлд дасан зохицоогүй тийм тохиолдол бараг үгүй билээ.

Борлаугийн дэлхий нийтийн ургамлын тариалалтад оруулсан энэхүү өөрчлөлт нь бидний цаашид даган мөрдөх өв болох нь үнэн. Гэхдээ шинжлэх ухааны судалгааг эрхлэн явуулж буй бидний хувьд тэрээр өөр нэгэн өв үлдээсэн нь тэрээр эрсдлээс огтхон ч айдаггүй явдал байлаа. Тэрээр томоохон хэмжээний асуудлыг томоохон хэмжээний судалгаа хийсний үндсэн дээр шийдэх чиглэлд ажиллан, хүнсний баталгаат байдалд үзүүлэх нөлөө нь эерэг, хурдан хугацааны байх төслүүд дээр ажиллаж байлаа.

Шинжлэх ухаан, технологи нь дэлхий нийтийн хүмүүсийн сайн сайхны төлөө үйлчлэх ёстой гэдгийг тэр батлан харуулсан юм. Тэрээр өөрийн амьдралын сүүлийн жилүүдэд хэрэв шинжлэх ухаан нь цаашид хүн төрөлхтний нөхцөл байдлыг сайжруулах зорилготой л бол цаашид тулгарч буй сорилтууд нь шинэ арга хэрэгсэл, шинэ стратеги болон шинэ ой ухааныг шаардаж буйг сайтар ухаарч байлаа. Хөдөө аж ахуйн салбарт тэрээр өөрийн өвийг үлдээж энэхүү өвөө цаашид ажил хэрэг болгох замыг зассан билээ.

Adapting Borlaug ’s Legacy for a New Era

New challenges make it necessary that we again transform agriculture through science and new technologies. Our food production systems face many challenges that threaten our ability to provide a safe, adequate, and nutritious food supply. The U.N.’s Food and Agriculture Organization predicts that food production must double by 2050 to meet global demand, even as it faces new threats. Our food supply must adequately address nutritional issues that range from obesity to malnutrition. Additionally, we need to develop processes and technologies that protect our food from microbial contamination.

Even as demand for food grows, competition for the energy needed to produce it increases. The International Energy Outlook 2009, published by the U.S. Department of Energy, projects that total world consumption of marketed energy will increase by 44 percent from 2006 to 2030, most notably in China and India. New renewable energy sources must enter the production chain if we are to assure adequate food supply. Agriculture can play a key role in developing those energy sources.

Agricultural science must respond to these pressures, both to ensure the sustainability of the U.S. food, fuel, and fiber system and to address some of the world’s most intractable problems. In this spirit, Borlaug would have welcomed the National Academy of Sciences’ new report, A New Biology for the 21st

The Agriculture Research Service of USDA is enhancing the phytonutrient content and longevity of tomatoes with genetic engineering techniques. This scientist is working at an agency laboratory in Beltsville, Maryland.

Courtesy of Scott Bauer/USDA

АНУ-ын Хөдөө аж ахуйн яамны харьяа Хөдөө аж ахуйн судалгааны төв нь генетикийн инженерчлэлийн аргыг ашиглан улаан лоолийн фито-тэжээллэгийн агууламж болон амьдрах чадварыг сайжруулж байна. Зураг дээрх судлаач Мэриланд мужийн Белтсвил хотын лабораторид ажиллаж байгаа нь.

Борлаугийн өвийг шинэ эринд зохицуулан хэрэгжүүлэх нь

Шинээр тулгарч буй сорилтуудаас харахад бид хөдөө аж ахуйг шинжлэх ухаан, шинэ технологийн тусламжтайгаар шинэчлэх шаардлагатай болох нь харагдаж байна. Бидний хүнсний үйлдвэрлэлийн систем нь олон тооны сорилттой тулгаран, үүний улмаас аюулгүй, тэжээллэг, хангалттай хэмжээний хүнсээр хүн амыг хангах бидний боломжид заналхийлж байна. НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллагаас дэлхий нийтийн эрэлтийг хангахын тулд хүнсний үйлдвэрлэл 2050 он гэхэд хоёр дахин нэмэгдсэн байх ёстой хэмээн таамаглаж байна. Манай хүнсний хангамж нь илүүдэл жингээс эхлээд тэжээлийн дутагдал хүртэлх бүх төрлийн асуудалд хандсан байх шаардлагатай. Түүнчлэн бид хүнсний бүтээгдэхүүнийг микробын бохирдлоос хамгаалах үйл ажиллагаа, процессыг боловсруулах шаардлагатай байна.

Хүнсний бүтээгдэхүүний эрэлт ихэссэн ч гэсэн үүнийг үйлдвэрлэхэд шаардлагатай эрчим хүчний өрсөлдөөн нэмэгдсээр байна. АНУ-ын Эрчим хүчний яамнаас нийтлүүлсэн Олон улсын эрчим хүчний төлөв байдал 2009 илтгэлд дурдсанаар, дэлхийн хэмжээнд зах зээлд нийлүүлж буй эрчим хүчний хэрэглээ нь 2006- 2030 онуудад 44%-иар өсөх бөгөөд энэхүү өсөлтийн ихэнх хувь нь Энэтхэг болон Хятад улсуудад ноогдох ажээ. Хүнсний хангамжийг хангалттай байлгахын тулд үйлдвэрлэлийн сүлжээнд сэргээгдэх эрчим хүчний шинэ эх үүсвэрийг нэвтрүүлэх шаардлага урган гарч байна. Энэхүү эрчим хүчний эх үүсвэрийг хөгжүүлэхэд хөдөө аж ахуй голлох үүргийг гүйцэтгэх нь дамжиггүй.

Хөдөө аж ахуйн шинжлэх ухаан энэхүү бүх шахалт, асуудлуудыг даван гарч АНУ-ын хүнс, түлш, ноосны хангамжийн системийг тогтвортой

Century, as the next great step in harnessing science to solve societal challenges. Its recommendations speak to values he held dear:

- Taking bold, risk-taking approaches to understanding fundamental questions in biology;
- Tackling complex scientific challenges with a laser-tight focus on areas where the "new biology" can offer the most promise of transformative breakthroughs;
- Scaling up research efforts across disciplinary boundaries to match the complexity and magnitude of 21st-century problems;

The National Institute for Food and Agriculture conducts research to achieve national objectives, such as improving childhood nutrition. These New York City students are eating in a school cafeteria where they are served nutritious, low fat, and locally grown food.

© AP Images/Mary Altaffer

Үндэсний хүнс, хөдөө аж ахуйн хүрээлэн нь хүүхдийн тэжээллэгийг сайжруулах үндэсний хэмжээний судалгааг хийж байна. Зураг дээрх Нью Йоркын сурагчид орон нутагт ургуулсан, эрүүл, тэжээллэг хоол хүнсийг сургуулийн кафед идэж байна.

байлгахын хажуугаар дэлхийд тулгараад буй зарим нэгэн хүндхэн асуудлыг шийдэх боломжтой байх шаардлага мөн тулгарч байна. Энэхүү үйлсийн хүрээнд Үндэсний шинжлэх ухааны академийн гаргасан 21 дүгээр зууны шинэ биологи хэмээх тайланг Борлауг талархан хүлээн авч, нийгмийн сорилтуудыг шийдвэрлэхэд шинжлэх ухааныг дайчлах дараагийн томоохон алхам эхэллээ хэмээн сайшаах байсан буйзаа. Энэхүү тайланд дурдсан санал зөвлөмжүүд нь түүний эрхэмлэж байсан үнэт зүйлсийг тусгасан бөгөөд, үүнд:

- Биологийн суурь асуудлуудыг ойлгохын тулд зоримог, эрсдэлтэй хандлагыг баримтлах,
- "Шинэ биологийн" хүрээнд шилжилтийн эрс өөрчлөлтийг гаргаж чадах салбарууд дээр шинжлэх ухааны ээдрээтэй асуудлуудыг хурц хараагаар төвлөрөн судлах,
- 21 дүгээр зуунд тулгарах асуудлуудын ээдрээ болон цар хүрээг зохистой шийдэх зорилгоор судалгаанаас гарсан үр дүнг өргөн хүрээнд түгээх,
- Шинжлэх ухаанд гаргаж буй бидний дэвшил нь хүний эрүүл мэнд, хүнсний баталгаат байдал болон хүрээлэн буй орчны асуудалд эерэг нөлөөгөөрөө хэмжигдэж байхыг баталгаажуулах.

Шинэ биологи тайлан нь тулгараад буй асуудлуудын цар хүрээ, түүнийг шийдэхэд шаардагдах шинжилгээ, судалгааны үйл

- Ensuring that our progress in science is measured by tangible impacts on human health, food security, and environmental stewardship.

The New Biology report recognizes the magnitude of these challenges and of the research effort required to meet them. The report explains how future advances will rely upon a more fundamental understanding of plant life itself:

The long-term future of agriculture depends on a deeper understanding of plant growth. Growth — or development — is the path from the genetic instructions stored in the genome to a fully formed organism. Surprisingly little is now known about this path in plants. A genome sequence provides both a list of parts and a resource for plant breeding methods, but does not give the information needed to understand how each gene contributes to the formation and behavior of individual plant cells, how the cells collaborate and communicate to form tissues (such as the vascular system, or the epidermis), and how the tissues function together to form the entire plant.

The report recommends deploying new technologies to help understand how plants grow and thrive, including modeling and simulation tools to visualize growth and development at the cellular and molecular levels. The goal, the report says, is a more efficient approach to developing plant varieties that can be grown sustainably under diverse local conditions. Developing these new tools will make possible new methods and techniques to address problems in health, energy, and environment as well as traditional agriculture.

We take precisely this approach at the U.S. Department of Agriculture. We are committed to combating world hunger by developing new crop varieties that can grow and thrive under environmental stress. We will employ every means in the science toolkit to this end; we cannot afford to ignore any scientific field that promises breakthroughs toward global food security. We know that this research will yield collateral health, energy, and environmental benefits. The advances will help American farmers remain competitive in the global agricultural marketplace, even as we reduce the toll from starvation and malnutrition in other countries.

Today's challenges require more than new ideas and new tools. A new approach to how research is

ажиллагааг тодорхойлсон билээ. Тайланд дурдсанаар ирээдүйн дэвшлүүд нь хэрхэн ургамлын амьдралын үндсэн ойлголт дээр суурилаж болохыг тайлбарласан бөгөөд, үүнд:

Хөдөө аж ахуйн урт хугацааны ирээдүй нь ургамлын ургалтын талаарх гүнзгий ойлголт, мэдлэгт тулгуурлах болно. Ургалт буюу хөгжил нь генид хадгалагдсан генетикийн мэдээлэл бүрэн бүрэлдсэн организм бий болон өсөх зам билээ. Гайхалтай нь ургамлын энэхүү замын талаар тун бага хэмжээний мэдлэгтэйд байгаа юм. Гений дараалал нь хэсэг бүрийн жагсаалт болон ургамлыг үржүүлэх эх үүсвэрийн талаарх мэдээллийг хангадаг хэдий ч гени болгон нь тухайн ургамлын бүтэц бий болох болон эд эс бүрийн шинж чанарт нөлөөлдөг, эд эсүүд хэрхэн нийлж дараагийн бүтцийг үүсгэдэг (жишээ нь эрхтэн болон хальс гэх мэт), улмаар хэрхэн цааш ургамал болон өсдөг процессын талаар ямар нэгэн мэдээлэл агуулдагггүй.

Тайлан дээрх санал зөвлөмжүүд нь ургамал хэрхэн ургаж, хөгждөг талаар, тэр тусмаа эд, эсийн түвшинд хэрхэн ургаж хөгждөг болохыг загварчлалын болон симуляцын аргачлалыг ашиглан боловсруулан, ойлголтыг нэмэгдүүлэхэд шинэ технологийг ашиглахыг санал болгосон юм. Тайланд дурдсанаар хамгийн гол зорилго нь орон нутгийн олон төрөл нөхцөлд тогтвортойгоор ургаж чадах ургамлын төрөл зүйлийг бий болгох үр дүнтэй хандлагыг бий болгох явдал юм.

Эдгээр шинэ аргачлалыг боловсруулах нь боломжит шинэ арга, техникүүдийг бий болгон, эрүүл мэнд, эрчим хүч, хүрээлэн буй орчин болон уламжлалт хөдөө аж ахуйд тулгараад буй асуудлуудыг шийдэх боломжийг бий болгох юм.

Энэхүү хандлагыг АНУ-ын Хөдөө аж ахуйн яам нухацтайгаар мөрдөж байна. Байгаль орчны хахир хатуу нөхцөлд ургаж чадах ургамлын шинэ төрлийг гарган авснаар, бид дэлхийн хэмжээнд тулгарч буй өлсгөлөнгийн эсрэг тэмцэнэ хэмээн зүтгэж буй билээ. Энэхүү зорилгодоо бид шинжлэх ухаанд хэрэглэж буй бүх аргачлалыг ашиглах бөгөөд энэхүү салбарт шинэ дэвшлийг авчирч болох шинжлэх ухааны ямар нэгэн салбарыг хайхралгүй үлдээж болохгүй юм. Энэхүү судалгаа нь эрүүл мэнд, эрчим хүч болон байгаль орчны салбарт хамаарах үр нөлөөг үзүүлнэ хэмээн бид ойлгож байгаа. Үүний үр дүнд гарах дэвшил нь Америкийн фермерүүдэд дэлхийн зах зээл дээр өрсөлдөх чадвараа хадгалан үлдэхэд туслахын хажуугаар бусад улс оронд тохиож буй өлсгөлөн болон хоол тэжээлийн дутагдлыг багасгах боломжийг олгоно.

Өнөөгийн сорилтууд нь шинэ санаа, шинэ аргачлалаас хавьгүй илүү зүйлсийг шаардаж байна. Судалгаа шинжилгээг хэрхэн удирдах, санхүүжүүлэх шинэ хандлага, мөн үүний амжилт ололтыг хэрхэн хэмжиж байх зэргийг эрчимтэй шаардаж байна. АНУ-ын Хөдөө аж ахуйн яамны хувьд энэхүү шинэ аргачлалын анхны алхам нь

Courtesy of Bruce Fritz/USDA

Scientists with the USDA's Agriculture Research Service examine different samples of alfalfa, genetically engineered for improved characteristics such as leaf retention and disease resistance.

АНУ-ын Хөдөө аж ахуйн яамны харьяа Хөдөө аж ахуйн судалгааны төвийн ажилтнууд генетикийн инженерчлэлийн аргаар навчны ургац болон өвчин эсэргүүцэх чадварыг нь сайжруулсан царгасны төрөл бүрийн дээжийг шалгаж байгаа нь.

funded and managed, and its successes measured, is required. For USDA, that new approach is represented by the National Institute of Food and Agriculture (NIFA), launched by Secretary of Agriculture Tom Vilsack in late 2009.

In setting up NIFA, USDA turned to colleagues in other U.S. government scientific agencies to identify "best practices" for managing federal grants. Among the lessons we learned and will implement:

- Greater transparency and accountability will inform our grantmaking.
- We shall resolve many problems into a limited and discrete set of issues and tackle their root causes.

2009 оны сүүлээр Хөдөө аж ахуйн сайд Том Вилсакын албан ёсоор нээсэн Үндэсний хүнс, хөдөө аж ахуйн хүрээлэн болж байна.

Энэхүү хүрээлэнг анх байгуулахдаа Хөдөө аж ахуйн яам АНУ-ын Засгийн газрын бусад шинжлэх ухааны агентлагуудад хандан, тэднээс суралцан, холбооны санхүүжилтыг удирдах "шилдэг аргачлалуудыг" тодорхойлсон. Энэхүү сурсан сургамжаасаа бид доорх зүйлсийг хэрэгжүүлэх бөгөөд, үүнд:

- Ил тод болон хариуцлагатай байдлыг хангаснаар бидний олгож буй тэтгэлгийн талааарх мэдээлэл түгээх,
- Хязгаарлагдмал болон бие даасан асуудлуудын хүрээнд олон тооны асуудлыг шийдэн,

- Instead of trying to grow as many narrow, singleissue or single-focus research programs as we can, we shall identify and recruit the best minds — wherever they are — and make sure we retain their services and reward their work.

Now is the time carefully to assess and agree on broad but discrete challenges. By identifying these skillfully and deploying resources effectively, we can help solve large and previously intractable societal problems — climate change, food safety, child nutrition and obesity, food security at home and abroad, abundant and renewable energy — and hold the promise of doing so while preserving and improving our environment and generating wealth in rural America and the world.

Norman Borlaug applied agricultural science and technology to the challenging issues of his day. NIFA aims to honor his legacy by securing equally transformative change. Working with partners in the United States and other nations, we can build on recent scientific discoveries — incredible advances in sequencing plant and animal genomes, for example. We have new and powerful tools — biotechnology, nanotechnology, and large-scale computer simulations — applicable to all types of agriculture. Agriculture is a science and must draw widely from many disciplines and many technologies, but our science portfolio needs to be tightly focused to leverage other resources and to prioritize its efforts. With this approach, we can match Norman Borlaug's remarkable record of improving the health and well-being of our global society.

тэдгээрийг үүсгэж буй үндэс суурийг шийднэ,

- Хязгаарлагдмал, нэг асуудалд хандсан, нэг төвлөрөл бүхий судалгааны хөтөлбөрөөс илүүтэйгээр, бид хамгийн шилдэг оюун ухаан, мэдлэгийг тодорхойлон тэднийг ашиглан, тэдний үйлчилгээг авч, амжилт бүтээлийг үнэлнэ.

Харин одоо өргөн хүрээний, онцлог сорилтуудыг үнэлэн, тэдгээрийн цар хүрээг үнэлэх цаг болоод байна. Эдгээрийг ур чадвартайгаар тодорхойлон, нөөц эх үүсвэрийг үр дүнтэйгээр хэрэглэснээр бид ихээхэн том хэмжээний, ноцтой нийгмийн асуудлуудыг шийдэж чадах ба үүний тоонд уур амьсгалын өөрчлөлт, хүнсний аюулгүй байдал, хүүхдийн хоол тэжээл, дотоодын болон гадаадын хүнсний баталгаат байдал, сэргээгдэх эрчим хүч зэрэг багтана. Эдгээр үйл ажиллагааг явуулахдаа өөрийн байгаль орчныг хадгалан, сайжруулж, баялагийг Америкийн хөдөө нутаг болон олон улсад бий болгох болно.

Норман Борлауг өөрийн цаг үедээ хөдөө аж ахуйд тулгарсан сорилтуудыг шийдэхээр шинжлэх ухаан, технологийг ашигласан. Үндэсний хүнс, хөдөө аж ахуйн хүрээлэн нь түүний үлдээсэн өвийг хүндэтгэн, тэгш шилжилтийн өөрчлөлтийг баталгаажуулж байна. АНУ болон бусад улсууд дахь түншүүдтэйгаар хамтран ажилласнаар бид ургамал, амьтны генийн дараалыг тогтоох чиглэлд гаргасан амжилт дээрээ суурилан цаашид хөгжих болно. Одоо бидэнд шинэ, хүчирхэг аргачлал болох биотехнологи, нанотехнологи болон компьютерийн симуляц байгаа нь хөдөө аж ахуйн бүх салбарт ашиглагдах боломжтой билээ. Хөдөө аж ахуй нь олон салбар, олон технологиос хамааралтай салбар хэдий ч бидний шинжлэх ухааны багц нь бусад нөөц эх үүсвэрүүдийг дайчлах болон хүчин чармайлтуудаа эрэмбэлэхэд анхаарна. Энэхүү хандлагыг ашигласнаар бид дэлхий нийтийн хүн амын эрүүл мэнд, сайн сайхан байдлыг сайжруулж чадсан Норман Борлаугийн гайхалтай түүхийг давтаж чадах юм.

Feeding the “Hidden Hunger”

Meeting the world’s future food needs will test the capacity and ingenuity of agriculture producers everywhere. The problem is one not merely of quantity, but of quality. More than 1 billion people lack adequate amounts of nutrient-rich foods such as meat, eggs, milk, and vegetables, according to a 2009 U.N. Food and Agriculture Organization estimate.

“Hidden hunger” is how the Micronutrient Initiative, one of the advocacy groups seeking solutions to the problem, describes malnutrition. “When hidden hunger is widespread, it can trap families, communities and whole nations in cycles of ill health and poverty,” the organization explains on its Web site.

Childhood deficiencies of key vitamins and nutrients that support proper growth can saddle youngsters with lifetime disabilities.

Supplying all the world’s people today and in the future with abundant nutrient-rich foods is the most desirable, but the most difficult, solution. Other answers are to distribute nutrient supplements — vitamin pills — to populations, or to provide fortified foodstuffs like iodized salt and milk with added Vitamin D and calcium. These solutions received support in a United Call for Action from a coalition of many of the world’s major aid agencies in 2009, including the U.S. Agency for International Development and the U.N. Children’s Fund.

Still another answer to malnutrition is biofortification — creating new versions of staple food crops that come out of the ground with higher nutrient content.

“Далд өлсгөлөнг” тэжээхүй

Дэлхийн хүнсний хэрэгцээг хангах асуудал нь хөдөө аж ахуйн салбарын хүчин чадал, фермерүүдийн бизнесийн ур ухаанаас шалтгаалж байна. Ялангуяа, хүнсний хэрэгцээ нь зөвхөн тоо хэмжээнээс гадна хүнсний бүтээгдэхүүний чанартай холбоотой. 2009 онд явуулсан НҮБ-ын Хүнс хөдөө аж ахуйн байгууллагын судалгаагаар бараг 1 тэрбум гаруй хүн мах, өндөг, сүү, хүнсний ногоо зэрэг тэжээллэг хоол хүнсээр дутагдаж байгаа нь тогтоогджээ.

Бичил тэжээл санаачлага нэртэй олон улсын байгууллага “Далд өлсгөлөн” гэж нэрлэгдэж буй энэ асуудлыг шийдвэрлэх арга замуудыг идэвхтэй эрэлхийлж байгаа бөгөөд далд өлсгөлөн гэдэг нь хоол тэжээлийн дутагдалтай холбоотой гэж тодорхойлж байна. Тус байгууллагын веб хуудсанд бичсэнээр “далд өлсгөлөн газар авснаар тухайн өрх, хот тосгоны оршин суугчдаас гадна нийт улс үндэстэн ядуурал нэрвэгдэж, хүн амын дунд өвчлөл эрс нэмэгддэг байна.”

Нялх балчир насандаа витамин, тэжээллэг хоол хүнсээр дутагдаж байсан өсвөр насны хүүхдүүд бүх насаараа бие бялдарын доройтол, өвчин эмгэгт өртөмтгий болдог.

Дэлхийн нийт хүн амыг тэжээллэг, илчлэг сайтай хоол хүнсээр хангана гэдэг нь хүндхэн сорилт гэдгийг хүлээн зөвшөөрч байна. Одоогийн байдлаар хүн амын тэжээлийн дутагдлыг нөхөх зорилгоор витамин, иоджуулсан давс, Д витамин, кальциар баяжуулсан сүүгээр хангах зэрэг арга хэрэглэж байна. 2009 онд АНУ-ын Олон улсын хөгжлийн агентлаг, НҮБ-ын Хүүхдийн сан зэрэг олон улсын томоохон тусламжийн байгууллагууд хамтран Үйл ажиллагааны төлөө нэгдмэл уриалга нэртэй тусгай хөтөлбөр хэрэгжүүлсэн юм.

Тэжээлийн дутагдлыг арилгах өөр нэг арга нь орчин үеийн хөдөө аж ахуйн технологийг ашиглан ургацын тэжээллэг чанарыг нэмэгдүүлэх арга юм. Сонгон үржүүлэх замаар гаргаж авсан шинэ төрлийн ургац нь энгийн ургацтай харьцуулахад илчлэг өндөртэй, хамгийн гол нь хоол хүнсний тогтвортой эх үүсвэр болох чадвартай.

HarvestPlus, one international agricultural research project, is pursuing this solution with efforts to boost the nutrient content of seven key staple crops grown in Asia and Africa. These crops are beans, cassava, maize, pearl millet, rice, sweet potato, and wheat.

Sometime later this year, HarvestPlus aims to get the first biofortified crop into the ground. A strain of beans with a higher than average iron content has been bred for cultivation in Rwanda and the Democratic Republic of Congo where up to 50 percent of children can suffer from an iron-deficient diet.

By 2011-2012, HarvestPlus aims to develop a strain of cassava that will triple the Vitamin A content of the starchy staple crop and provide about half of the recommended amount of the vitamin necessary for proper vision. Though still in development, the biofortified cassava is set to be in the fields of Nigeria and the Democratic Republic of Congo by 2011-2012.

In a HarvestPlus pilot project, Ugandan women grow a sweet potato variety that is higher in Vitamin A content than the strains widley grown at present. The increased vitamin content of this food staple can help protect the population from infection and blindness.

Courtesy of Anna Marie Ball/HarvestPlus

ХарвестПлас төсөл нь хөдөө аж ахуйн судалгааны чиглэлээр дагнасан олон улсын төсөл бөгөөд энэ төслийн хүрээнд Ази, Африк тивийн улс орнуудад тариалдаг 7 гол ургацын илчлэг, тэжээллэг чанарыг нэмэгдүүлэх туршилт хийж байна. Үүнд буурцаг, кассава, эрдэнэ шиш, хар будаа, цагаан будаа, амтат төмс, улаан буудай зэрэг 7 төрлийн ургацыг туршилтанд хамруулсан.

Энэ оны сүүлчээр ХарвестПлас төслийн хүрээнд үржүүлгийн аргаар гаргаж авсан ургацын үрийг тариалж эхэлнэ. Тухайлбал, Руанда, Бүгд Найрамдах Ардчилсан Конго улсуудад төмрийн агууламж өндөртэй шинэ төрлийн буурцаг тариалж байна. Учир нь төсөлд хамрагдсан дээрхи 2 улсад нийт хүүхдүүдийн бараг 50 хувь нь төмрийн дутагдалтай гэсэн судалгаа гарчээ.

ХарвестПлас төслийн хүрээнд 2011-2012 онд энгийн кассавагаас 3 дахин их А витамин агуулдаг шинэ төрлийн кассава гаргаж авахаар ажиллаж байна. Шинэ төрлийн кассава нь нүдний хараг хэвийн байлгахад шаардагдах витаминаар хангах юм. Одоогоор судалгааны ажил үргэлжилж байгаа бөгөөд 2011-2012 онд шинэ төрлийн кассаваг Нигери, Бүгд Найрамдах Ардчилсан Конго улсад тариалахаар төлөвлөж байна.

ХарвестПлас төсөлд хамрагдсан Уганда эмэгтэй А витамины агууламжаараа бусад төрлийн төмснөөс харьцангуй илүү, шинэ төрлийн амтат төмс тариалжээ. Амтат төмсний витамины агууламжийг нэмэгдүүлснээр Уганда улсын хүн амыг элдэв төрлийн халдварт өвчин болон нүдний хараа муудах, сохрох эрсдлээс сэргийлж чадна.

Crops Will Provide 21st-Century Energy

Elisa Wood

As nations hunt for ways to fulfill their population's food needs in the future, the need to identify cleaner energy sources is also urgent. In the future, agriculture will likely meet some portion of energy production, and various nations are pursuing this potential today.

Elisa Wood specializes in energy issues and her work is available at www.RealEnergyWriters.com.

One partial solution to our energy problems lies not in the oilfield but in the cornfield, as nations increasingly replace some petroleum needs with bioenergy — fuel made from plants. "Energy farming" increases demand and opens vast new markets for crops: for sugarcane in Brazil, for corn and soybeans in the United States, and for other grasses, seeds, and trees in other nations.

Crop-Based Fuels in the United States

Many nations already use bioenergy to run cars and trucks, often in a mix with gasoline or diesel fuel. The two major forms of crop-based fuel used in the United States are ethanol from corn and biodiesel from soybeans.

The market for these fuels is expected to grow. As U.S. liquid fuel needs expand over the next 25 years, bioenergy will help fill the gap, according to the U.S. Energy Information Administration. Europe, Asia, and Central and South America also rely increasingly on this resource.

Bioenergy holds special appeal because it is renewable — simply by growing agricultural crops. We cannot replenish petroleum, today's leading source of most transportation fuel. Economists say

Ургац нь 21-р зууныг эрчим хүчээр хангана

Элиса Вүүд

Дэлхийн улс орнууд хүн амынхаа хүнсний хэрэгцээг хангахын төлөө нэлээд хүчин чармайлт гаргаж байна. Зөвхөн хоол хүнсний хэрэгцээг хангах нь чухал биш, хүрээлэн буй орчинд хор хөнөөлгүй эрчим хүчний шинэ эх үүсвэр гарган авах асуудал ч хурцаар тавигдаж байна. Ойрын ирээдүйд хөдөө аж ахуйн салбар нь зөвхөн хоол хүнснээс гадна хүн төрөлхтний эрчим хүчний хэрэгцээний тодорхой хувийг хангах үүрэг хүлээх бололтой.

Судлаач Элиса Вүүд эрчим хүчний асуудлыг дагнан судалгаа хийдэг бөгөөд түүний бүтээлүүдийг www.RealEnergyWriters.com веб хуудаснаас үзэж болно.

Газрын тосны орд нь эрчим хүчний цорын ганц эх үүсвэр биш болжээ. Учир нь дэлхийн зарим улсад түлш шатахууныхаа хэрэгцээний тодорхой хувийг ургамлаас гаргаж авсан био түлшээр хангаж байна. Эрчим хүчний ферм хэмээх шинэ ойлголт бий болсноор ургац нийлүүлэх шинэ зах зээлтэй болж байна гэсэн үг. Жишээлбэл, Бразилд чихрийн нишингэ, АНУ-д үр тариа, буурцгийн шош эрэлттэй бүтээгдэхүүн болжээ.

АНУ-д ургац нь түлшний чухал эх үүсвэр болжээ

Дэлхийн олон улс оронд био түлшийг автомашин, тээврийн хэрэгслийн шатахуун болгон ашиглаж байна. Био түлшийг голдуу бензин, дизель түлштэй хольж хэрэглэдэг. АНУ-д гаргаж авдаг био түлшний үндсэн 2 эх үүсвэр нь үр тарианаас гаргаж авдаг этанол, буурцгийн шошноос гаргаж авдаг биодизель юм.

Зах зээл дээрхи био түлшний эрэлт хэрэгцээ цаашид улам нэмэгдэх төлөвтэй байна. АНУ-ын Эрчим хүчний мэдээллийн газраас явуулсан судалгаагаар, ирэх 25 жилийн хугацаанд АНУ дахь шингэн түлшний хэрэгцээ огцом нэмэгдэх төлөвтэй байгаа бөгөөд био түлш нь энэ хэрэгцээний тодорхой хувийг нөхөх бололцоотой гэнэ. Европ, Ази, Төв болон Өмнөд Америкийн улс орнуудад ч гэсэн био түлшинд онцгой анхаарал хандуулж эхэлсэн.

Био түлш нь ургацанд тулгуурладаг учраас нөхөн сэргээгддэг эрчим хүчний эх үүсвэр гэж тооцогддог юм. Харин өнөөдөр автомашины гол

that as petroleum supplies diminish, we can expect prices will rise. Experts predict that bioenergy will serve as a 21st-century answer.

"Biofuels play a very, very major role in displacing petroleum-based fuels," says John Urbanchuk, a bioenergy specialist with LEGC Consulting, an expert services consulting firm with offices worldwide. Indeed, if the United States replaced just 5 percent of today's diesel with renewable fuels, it could displace as much crude oil as it now imports from Iraq for diesel production, according to the National Biodiesel Board, which Urbanchuk advises.

"And there are other benefits as well," Urbanchuk adds. "Biofuels provide market-based revenue for farmers, which is very important. If you can provide a marketbased return that reduces the amount of

In Brazil, sugarcane waste is used to produce ethanol, which is mixed with gasoline in a mandated formula for automobile fuel.

© AP Images/Andre Penner

Бразил улсад чихрийн нишингэний хаягдалыг этанол гарган авахад ашиглаж байна. Гаргаж авсан этанолыг шатахуунтай хольж боловсруулснаар автомашины түлш болгон ашигладаг юм.

тэжээл болж байгаа шатахуун нь нөхөн сэргээгдэх боломжгүй юм. Шатахууны нийлүүлэлт багасвал шатахууны үнэ өснө. Харин дэлхийн тэргүүлэх эдийн засагчид, шинжээчдийн тооцоолж байгаагаар био түлш нь 21-р зууны шатахууны хэрэгцээг хангах гол эх үүсвэр болж магадгүй гэнэ. ЛЕГГ Консалтинг компанийн шинжээч Жон Урбанчук био түлшийг газрын тосыг орлож чадах эрчим хүчний шинэ эх үүсвэр гэж нотолж байна.

Хэрвээ АНУ дизель түлшнийхээ хэрэгцээний 5 хувийг л био түлшээр орлуулсан тохиолдолд Иракаас импортолдог түүхий газрын тосоо хэмнэх ач холбогдолтой гэж Үндэсний биодизелийн зөвлөл мэдээлж байна.

Газрын тосыг био түлшээр орлуулах нь өөр олон давуу талтай гэнэ. Жишээлбэл, био түлшний зах зээлийн эрэлт нэмэгдсэнээр фермерүүдэд ч ашигтай болно. Хэрвээ фермерүүд био түлшний

government support that is provided to agriculture, that money can be used elsewhere."

Corn farmers, in particular, are reaping benefits from the bioenergy boom, because of a U.S. policy to increase the amount of ethanol in the gasoline mix. The nation added more than 34 billion kiloliters of ethanol to gasoline in 2008, using 3.2 billion bushels of corn. A federal mandate will quadruple ethanol production by 2022. As manufacturers expand, they will need more corn. By 2018 ethanol production will likely account for 35 percent of U.S. corn use, according to the U.S. Department of Agriculture.

Corn makes sense as an energy crop in the United States because "we grow corn, process corn better than anything else we do," says Urbanchuk. Corn is the nation's most widely produced feed grain, and the United States keeps finding more efficient ways to grow it. Last year the United States produced 13.2 billion bushels, a record crop, on 5 million fewer acres (2.02 million hectares) than the previous year.

Soybeans, the main crop for biodiesel, also are grown aplenty in the United States. The nation is the world's largest producer and exporter of soybeans, with almost 400,000 farmers in 29 states growing them. U.S. sales of biodiesel fuels, blended or used in pure form, totaled 1.7 million kiloliters for 2009. As one bushel of soybeans can produce 1.4 gallons (5.3 liters) of soy-based biodiesel, farmers supplied nearly 328 million bushels of soybeans to renewable biodiesel in 2009 alone.

International bioenergy drive

Biofuels and wind are expected to be the fastest growing renewable energy resources in the 30 countries making up the Organization for Economic Cooperation and Development. Estimates are that India will expand biofuel use 15 percent over the next two decades, and China 10 percent. Biofuel industry growth also is under way in various South American countries.

But the United States and Brazil are the leaders, and are expected to remain so. The two countries produce 70 percent of the world's bioenergy. While the United States produces more ethanol, Brazil is often described as the first biofuel economy. Backed by substantial government investment, Brazil for

---

үндсэн түүхий эдийг нийлүүлэх замаар ашиг олж, зардлаа нөхөж чадвал засгийн газраас хөдөө аж ахуйн салбарт татаас болгон олгодог хөрөнгийг өөр зүйлд зарцуулах боломжтой юм.

АНУ-ын засгийн газар холимог шатахуун дахь этанолын хэмжээг нэмэгдүүлэх бодлого баримталж байгаа нь үр тарианы фермерүүдэд ч ашиг тустай юм. Учир нь био түлшний хэрэгцээ нэмэгдэхийн хэрээр үр тарианы эрэлт нэмэгдэнэ гэсэн үг. 2008 онд АНУ-д 3.2 тэрбум бушель үр тариагаар нийт 34 тэрбум килолитр этанол гарган авч, түлшинд ашиглажээ. Холбооны засгийн газар 2022 он гэхэд этанолын үйлдвэрлэлийг бараг 4 дахин нэмэгдүүлэхээр төлөвлөж байгаа юм. Өөрөөр хэлбэл этанолын үйлдвэрлэл нэмэгдэхийн хэрээр үр тарианы эрэлт нэмэгдэнэ гэсэн үг. АНУ-ын Хөдөө аж ахуйн яамны тооцоолсноор 2018 он гэхэд АНУ-д хурааж авсан нийт үр тарианы 35 хувийг этанол үйлдвэрлэхэд зориулан ашиглах гэнэ.

АНУ-д үр тариа нь зөвхөн хүнсний бүтээгдэхүүний үндсэн эх үүсвэрээс гадна түлш, эрчим хүчний гол эх үүсвэр болно гэдэгт Урбанчук итгэлтэй байгаа юм. Ялангуяа, АНУ-ын фермүүд хамгийн сайн чанарын үр тариагаараа алдартай. Үр тариа нь АНУ-ын газар тариалангийн салбарын хамгийн гол ургац бөгөөд засгийн газрын зүгээс ч гэсэн үр тарианы үйлдвэрлэлийг дэмжих олон янзын төсөл хэрэгжүүлдэг. Өнгөрсөн жил АНУ-д 13.2 тэрбум бушель үр тариа хурааж авсан бөгөөд өмнөх онтой харьцуулахад нийт тариалсан талбай нь 2.02 сая га талбайгаар бага байгаа нь ургацын гарц нэмэгдсэнийг илтгэж байна.

Биодизелийн гол түлш болох буурцгийн шош ч гэсэн АНУ-ын газар тариалангийн салбарт зонхилж байна. АНУ нь буурцгийн шошны үйлдвэрлэл, экспортын хэмжээгээрээ дэлхийд тэргүүлдэг бөгөөд одоогийн байдлаар АНУ-ын 29 мужийн 400,000 орчим фермд буурцаг тариалж байна. 2009 онд АНУ-ын зах зээл дээр холимог болон цэвэр байдлаар 1.7 тэрбум килолитр биодизель худалдаалагджээ. Өөрөөр хэлбэл 1 бушель буурцгийн шошоор 1.4 галлон (5.3 литр) биодизель гарган авна гэж тооцоолоход зөвхөн 2009 онд Америкийн фермерүүд биодизелийн үйлдвэрлэлд зориулан 328 сая бушель буурцгийн шош нийлүүлсэн гэсэн үг юм.

Олон улс дахь био эрчим хүч үйлдвэрлэл

Эдийн засгийн хамтын ажиллагаа хөгжлийн байгууллагын гишүүн 30 улсын дунд явуулсан судалгаагаар био түлш болон салхи нь нөхөн сэргээгдэх эрчим хүчний найдвартай эх үүсвэр болох магадлал өндөр байна. Ирэх 2 жилийн хугацаанд Энэтхэг улс био түлшний хэрэглээгээ 15 хувиар, Хятад улс 10 хувиар тус

Bioenergy: Available, Renewable, Sustainable

Bioenergy is energy derived from recently living organisms.

Bioenergy does not contribute to climate change because the carbon dioxide (CO_2) it produces is derived from carbon that existed in the atmosphere in the form of another recently living thing. Fossil fuels, on the other hand, release into the atmosphere greenhouse gases that were previously encased within the earth.

Biomass is the total mass of living matter within a given habitat, including commonly used fuels such as wood, but also a lot of items usually thought of as waste: agricultural waste, dung, municipal solid waste, industrial waste, and some crops that may be cultivated expressly for their use as fuels. Another attractive feature of biomass: It's just about everywhere, not concentrated in a few countries.

Tanks filled with ethanol made from the adjacent fields of sugarcane are seen in this view of Brazil's biofuel enterprise.

Courtesy of Anna Marie Ball/HarvestPlus

Бразилын нэгэн био түлшний үйлдвэрийн зураг. Зураг дээр этанолоор дүүргэсэн том савнууд харагдаж байна.

Био эрчим хүч: Олдоцтой, нөхөн сэргээгдэхүйц, мөн тогтвортой

Био эрчим хүчийг амьд организмын үлдэгдлээс гаргаж авдаг.

Өөрөөр хэлбэл био эрчим хүчнээс ялгардаг нүүрсхүчлийн давхар исэл нь амьд организмаас ялгардаг учраас уур амьсгалын өөрчлөлтөнд нөлөөлдөггүй. Харин нүүрс нь агаар мандалд хүлэмжийн хий ялгаруулдаг учраас уур амьсгалын өөрчлөлтийн гол шалтгаан юм.

Биомасс гэдэг нь тодорхой нутаг дэвсгэрийн хүрээнд хязгаарлагдсан нийт амьд организмын нийлбэр юм. Биомасс нь түлшний гол эх үүсвэр болох модноос гадна хөдөө аж ахуйн хаягдал, малын өтөг бууц,

Biomass is easy to grow, collect, use, and replace without depleting natural resources, so bioenergy is not only renewable, but also sustainable.

Ethanol, or ethyl alcohol as used in drinks and medicine, is currently the most widely used biofuel in the United States. About one-third of the U.S. corn crop is directed into ethanol production. This has led to a threefold increase in the amount of ethanol produced annually in the United States since 2003. About 34 billion kiloliters of ethanol were produced in the United States in 2009.

The U.S. Department of Energy supports research into new and cost-effective methods of developing liquid transportation fuels from abundant biomass sources such as crop and forestry residues.

three decades has been perfecting production of ethanol from sugarcane. No cars in Brazil run on pure gasoline anymore. The government requires that all vehicles run on blended fuel of about one-quarter ethanol. Brazil produced about 25,000 kiloliters of ethanol in 2008, and exported about 15 percent. Whether Brazil's success can be replicated remains a source of debate, given that few parts of the world have a climate and land mass so well suited for cultivating sugarcane.

In developing nations, biofuels already are commonly used, but as sources of domestic heating and cooking. Markets for biofuel crops have not developed, so they are not a source of revenue. That could change, however, given that several developing nations offer vast untapped bioenergy potential, according to a study, Certification Strategies, Industrial Development and a Global Market for Biofuels, by the Belfer Center for Science and International Affairs at Harvard University's Kennedy School.

While bioenergy could provide poor rural areas with a foundation for new agricultural industries, real challenges remain. Stable government is

хот суурин газрын хог, үйлдвэрийн хаягдал, ургацын хог зэрэг эрчим хүчний зорилгоор ашиглаж болох зүйлсийг ч агуулдаг. Биомасс нь зөвхөн тодорхой нэг улс оронд биш харин дэлхийн өнцөг булан бүрт элбэг тааралддаг зүйл юм.

Биомассын хэмжээ нь маш хурдан нэмэгддэг, цуглуулах, хэрэглэхэд хялбархан байдаг учраас байгалийн баялагт хэмнэлттэй. Тийм ч учраас био эрчим хүч нь зөвхөн нөхөн сэргээгдэх шинж чанартайгаас гадна эрчим хүчний тогтвортой эх үүсвэр гэж тооцогддог юм.

Этанол буюу этилийн спиртийг хүнсний болон эмийн зориулалтаар ашигладаг бөгөөд АНУ-д хамгийн өргөн хэрэглэгддэг био түлшний түүхий эд юм. АНУ-ын хэмжээнд хураагдсан нийт үр тарианы гуравны нэг хувийг этанолын үйлдвэрлэлд ашигладаг. 2003 оноос хойш АНУ-д 1 жилд үйлдвэрлэгддэг этанолын хэмжээ бараг гурав дахин нэмэгдсээр ирсэн нь ч үүнийг нотолно. Өнгөрсөн 2009 онд АНУ-д 34 тэрбум килолитр этанол үйлдвэрлэгджээ.

АНУ-ын Эрчим хүчний яам үр тариа болон модны үлдэгдлээс шингэн түлш гарган авах шинэ технологи боловсруулах чиглэлээр явуулж буй судалгааг идэвхтэй дэмждэг.

тус нэмэгдүүлэхээр төлөвлөж байна. Өмнөд Америкийн улс орнуудад ч гэсэн био түлшний хэрэглээ нэмэгдэх хандлага ажиглагдаж байгаа юм.

АНУ болон Бразил улсууд нь био түлшний үйлдвэрлэлээр дэлхийд тэргүүлсээр байна. Учир нь дэлхийн нийт био эрчим хүчний 70 хувь нь зөвхөн энэ хоёр улсад үйлдвэрлэгдэж байгаа юм. АНУ нь этанолын үйлдвэрлэлээр Бразил улсаас арай илүү боловч Бразилын эдийн засгийг бүхэлд нь био түлшинд тулгуурласан эдийн засаг гэж тодорхойлдог. Засгийн газраас хангалттай хөрөнгө оруулалт хийдэг учраас Бразилчууд чихрийн нишингэнээс этанол гаргаж авах талаар нэлээд туршлага хуримтлуулжээ. Жишээлбэл, Бразилд ганц ч автомашин цэвэр бензин хэрэглэдэггүй. Засгийн газар нь бүх автомашин тээврийн хэрэгслийг холимог түлш хэрэглэх, дор хаяж нийт шатахууны дөрөвний нэг хувь нь этанол байх шаардлага тавьдаг. Бразил улс 2008 онд 25,000 килолитр этанол үйлдвэрлэж, 15 хувийг нь экспортод гаргажээ. Гэвч Бразилын туршлагыг шууд хуулбарлах боломжгүй. Учир нь чихрийн нишингэ тариалахад тохиромжтой уур амьсгалын нөхцөл, асар их талбай зөвхөн Бразил улсад байгаа юм.

Хөгжиж буй улс орнуудад био түлшийг орон сууцны халаалт болон хоол хийхэд зориулан өргөнөөр ашиглаж байна. Био түлшний эрэлт

required to attract the investors and the capital to build the necessary infrastructure. Biofuel production requires refineries to make the fuel, cars that can use the fuel, and transportation facilities to bring the fuel to market.

Further, while ethanol is a cost competitive fuel, at about $60/barrel, the export market for biofuels "is being shaped haphazardly by a series of different and sometimes conflicting" government policy goals, the Belfer Center report says. For example, when

© epa/Kimimasa Mayama/CORBIS

A Japan Airlines 747-300 takes on biofuel and traditional jet fuel in a 50-50 blend at Haneda Airport in Tokyo in 2009. JAL is one of several airlines that have tested biofuels in flight, but these alternatives have not been introduced widely in the industry.

Токио хотын Ханеда нисэх буудал дээр зогсож байгаа Жапан Эйрлайнс нисэх компанийн 747-300 онгоц нь холимог түлш хэрэглэдэг. Уг онгоцны түлшний 50 хувийг этанол, 50 хувийг нь энгийн онгоцны түлш бүрдүүлдэг байна. Жапан Эйрлайнс компани нь био түлшийг нислэгийн үеэр туршсан хамгийн анхны нисэх компаниудын нэг юм. Гэвч иргэний нисэхийн салбарт био түлшний хэрэглээ төдийлөн нэмэгдэхгүй байна.

хэрэгцээ нь бага учраас үр тарианы компаниуд био эрчим хүчний салбарт төдийлөн ач холбогдол өгдөггүй байна. Гэвч Харвардын Их сургуулийн харьяа Кеннедигийн нэрэмжит сургууль дээр байрладаг Шинжлэх ухаан олон улсын харилцааны Белфер төвийн явуулсан судалгаагаар, ирээдүйд хөгжиж буй улс орнууд био эрчим хүчний томоохон үйлдвэрлэгч болох магадлалтай гэнэ. Энэ талаар Сертификацичлалын стратеги, аж үйлдвэрийн хөгжил ба био түлшний дэлхийн зах зээл нэртэй судалгааны төслийн тайлангаас харж болно.

Хэдийгээр био эрчим хүчний үйлдвэрлэл нь хөдөөгийн ядуу буурай фермерүүдийн хувьд зах зээлд өрсөлдөх шинэ бололцоо олгож байгаа боловч бэрхшээл олон байна. Био эрчим хүчний үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд их хэмжээний хөрөнгө оруулалт шаардлагатай учраас төр, засгийн газрын үйл ажиллагаа тогтвортой, төрөөс дэмжлэг сайтай байх ёстой. Био түлшний үйлдвэрлэл нь түлш гарган авах, цэвэрлэх төхөөрөмж, био түлш хэрэглэдэг автомашин, тээврийн хэрэгсэл, бэлэн бүтээгдэхүүнийг зах зээлд хүргэх зам тээврийн сүлжээ зэрэг өргөн ойлголтыг багтаадаг.

Одоогийн байдлаар дэлхийн зах зээл дээр 1 баррел этанол 60 ам. доллараар зарагдаж байгаа нь үнийн хувьд газрын тостой өрсөлдөх хэмжээнд байна гэсэн үг. Гэвч этанолын зах зээлийн үнэ нь олон хүчин зүйлсээс шалтгаалдаг. Тухайлбал, этанолын үнэ ханшны хэлбэлзэл нь тухайн засгийн газрын баримталж буй бодлогоос шалтгаалдаг болохыг Белфер төвийн судалгаа харуулж байна. Хөгжингүй аж үйлдвэржсэн улс орнууд дотоодын зах зээл болон фермерүүдийнхээ эрх ашгийг хамгаалах зорилгоор импортын бүтээгдэхүүнд хязгаарлалт хийх тохиолдол байдаг. Энэ хязгаарлалт нь хөгжингүй улс орнуудын зах зээлд нэвтрэх боломжийг хааж байгаа юм. Тус төвийн явуулсан судалгаагаар Суринам, Гайана, Болив, Парагвай, Бүгд Найрамдах Ардчилсан Конго, Камерун улсууд ирээдүйд этанолын экспортоор тэргүүлэх боломжтойг харуулсан.

developed countries restrict imports to protect their own farmers' profits, they make it more difficult for newcomers to enter the market. Still the study sees potential for production and export of sugarcane ethanol in Suriname, Guyana, Bolivia, Paraguay, the Democratic Republic of Congo, and Cameroon.

Most important, a nation must achieve food security before it channels agriculture resources into energy, says the report. Indeed, even in the United States, worries exist about the impact of biofuels on the food supply. During the food price hikes of 2007-2008, biofuels were named as a major culprit by groups such as the Earth Policy Institute. The use of corn for fuel increased demand for the crop, the Institute asserted, driving up prices for food uses as well. In retrospect, the U.S. Congressional Budget Office concluded that the diversion of corn to ethanol production effected food prices only minimally, accounting for between 0.5 and 0.8 percentage points of the 5.1 percent increase in the price of food. Other factors, such as skyrocketed energy costs, played a larger role in the food price spike, according to that office. But it is important for bioenergy advocates to address the perception that biofuels mean higher food costs. Many point out that not all of the grass or bean goes toward fuel. Meal and other byproducts are extracted for livestock feed and other purposes.

What's next?

While corn and soybean demand is expected to remain solid, other crops now in various stages of development will compete for use in biofuel production. For example, researchers at the University of Idaho's College of Agriculture and Life Sciences see strong possibilities for mustard seed, canola, and rapeseed. Mustard seed can serve a dual purpose: the oils can be made into biodiesel, and the pungent meal into a pesticide spread on farmland, says Jack Brown, professor of Breeding and Genetics at the University of Idaho.

Biofuels are not expected to displace petroleum entirely. But even if they only reduce petroleum use by a small amount, analysts expect their presence to put downward pressure on prices. In the case of biodiesel, Brown urges the farm industry to replace all of its petroleum fuel needs with biodiesel products.

Хамгийн гол нь тухайн улс орон хүнсний аюулгүй байдлаа харгалзан үзсэний дараа хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнийг эрчим хүчний үйлдвэрлэлд зарцуулах эсэхээ шийдэх хэрэгтэйг тайланд сануулсан. Зөвхөн хөгжиж буй улс орнууд төдийгүй АНУ-д ч гэсэн ургацыг био түлшний үйлдвэрлэлд ашигласнаар хүнсний нийлүүлэлт тасалдана гэсэн болгоомжлол байгаа юм. 2007-2008 онд дэлхийн хэмжээнд хүнсний бүтээгдэхүүний үнэ огцом нэмэгдсэн гол шалтгаан нь үр тариа, ургацыг био түлшний үйлдвэрлэлд ашигласантай холбоотой гэж Дэлхийн бодлогын хүрээлэн тайлбарлаж байсан. Өөрөөр хэлбэл үр тариаг био түлшний үйлдвэрлэлд ашиглах нь үр тарианы үнийг огцом нэмэгдүүлснээс гадна дагаад хүнсний бүтээгдэхүүний үнэ нэмэгдэх шалтгаан болжээ. Харин АНУ-ын Конгрессын Төсвийн газрын тайланд үүний эсрэг дүгнэлт хийсэн. Тухайлбал, уг тайланд үр тариаг этанолын үйлдвэрлэлд ашигласан нь үнийн өсөлтөнд бараг нөлөөлөөгүй гэж дүгнэжээ. Тухайн үед хүнсний бүтээгдэхүүний үнэ 5.1 хувиар өссөний дөнгөж 0.5-0.8 хувь нь үр тарианы үнэ нэмэгдсэнтэй холбоотой гэнэ. Харин үнийн өсөлтөнд нөлөөлсөн хамгийн гол хүчин зүйл нь цахилгаан эрчим хүчний үнэ огцом өссөнтэй холбоотой байжээ. Гэвч био эрчим хүчний үйлдвэрлэл нь хүнсний бүтээгдэхүүний үнийн өсөлтөнд тодорхой хэмжээгээр нөлөөлж байгааг анхаарлын гадна орхиж болохгүй. Хэдийгээр био түлш нь үр тариа болон бусад ургацанд тулгуурладаг ч гэсэн нийт хураагдсан ургацын зөвхөн тодорхой хувь нь л түлшний үйлдвэрлэлд ашиглагдаж байгааг ойлгох хэрэгтэй. Түүнчлэн үр тарианы үлдэгдэл, бусад дайвар бүтээгдэхүүнийг нь малын тэжээлд ашигладаг.

Дараа нь яах вэ?

Үр тариа болон буурцаг нь био түлшний хамгийн тогтвортой гол эх үүсвэрүүд гэж тооцогдож байгаа бөгөөд харин бусад төрлийн ургацыг био түлшний үйлдвэрлэлд ашиглах асуудал идэвхтэй яригдаж байна. Жишээлбэл, Айдахогийн Их сургуулийн Хөдөө аж ахуй, байгалийн шинжлэх ухааны коллежийн судлаачид гичний үр, канола, рапсын үрийг био түлш гарган авахад ашиглаж болох талаар судалгаа хийжээ. Жишээ нь гичний үрнээс гаргаж авсан тосыг биодизель гарган авахад ашиглахаас гадна хурц үнэртэй нунтаг үрийг нь тариан талбай дахь хортон шавжтай тэмцэхэд ашиглаж болно гэж Айдахогийн Их сургуулийн Генетикийн ухааны профессор Жек Браун зөвлөж байна.

Мэдээж хэрэг био түлш нь шатахууныг бүрэн орлож чадахгүй. Харин био түлшний хэрэглээ нэмэгдсэнээр шатахууны хэрэглээ тодорхой хэмжээгээр буурч, улмаар газрын тосны үнийн өсөлтийг хязгаарлах боломжтой. Жек Браун фермийн аж ахуй эрхлэгчдэд хандан шатахууны

Raw Materials of Biofuels
Био түлшний түүхий эд

First Generation
(technologies fully commercialized)
Нэгдүгээр үе
(Үйлдвэрлэлд өргөн ашиглагдаж байгаа технологиуд)

Raw Material/Түүхий эд	Use/Хэрэглээ
Corn, sugarcane, molasses, and sorghum/Үр тариа, чихрийн нишингэ, бурам, сорог	Ethanol/Этанол
Soybeans and other vegetable oils, recycled grease, beef tallow/Буурцаг, төрөл бүрийн ургамлын тос, хаягдал өөхөн тос, үхрийн өөх	Biodiesel/Биодизель

Second Generation
(emerging technologies)
Хоёрдугаар үе
(Шинэ боловсруулагдсан технологиуд)

Raw Material/Түүхий эд	Use/Хэрэглээ
Agricultural residue, including corn stover, wheat and plant rice straw, manure, and bagasse (residue from sugarcane and sorghum stalks)/Үр тариа, улаан буудай, цагаан будаа, малын өтөг, чихрийн нишингэ, сорогийн үлдэгдэл зэрэг хөдөө аж ахуйн хаягдал	Methane, cellulosic ethanol, power/Метан, целлюлозын этанол, цахилгаан станц
Forest biomass, including logging residues, wood/Мод бэлтгэлийн аж ахуйгаас үлдсэн хаягдал, мод зэрэг ойн биомасс	Cellulosic ethanol and power plant/Целлюлозын этанол, цахилгаан станц
Urban woody waste and landfills/Хот суурин газрын хог, модны үлдэгдэл	Methane, cellulosic ethanol, power/Метан, целлюлозын этанол, түлээ
Herbaceous plants, including switchgrass, miscanthus, reed canary grass, sweet sorghum, alfalfa/Шар будаа, мискантус, зэгс, амтлаг сорог, царгас зэрэг өвсөрхөг ургамал	Cellulosic ethanol, power plant/Целлюлозын этанол, цахилгаан станц
Short rotation woody crops, including willow, hybrid poplar, cottonwood pines, sycamore pines, eucalyptus/Уд, эрлийз улиас, нарс, агч мод, эвкалипт зэрэг модлог ургамлууд	Cellulosic ethanol, power plant/Целлюлозын этанол, цахилгаан станц

Information derived from The Economics of Biomass Feedstocks in the United States: A Review of the Literature, by the Biomass Research and Development Board

Эх сурвалж: The Economics of Biomass Feedstocks in the United States: A Review of the Literature, by the Biomass Research and Development Board

Tractors and trucks should be run on farm-grown fuels, he says, not only to support the industry, but also to protect farmland from pollutants emitted by petroleum. This would have a small but significant impact on petroleum use — agriculture makes up just over 1 percent of U.S. gross national product. “Even if biodiesel became everything we want it to be, it would still produce only [a] small quantity of the fuel we need in this country. That is why biodiesel should not be used by Mrs. McGuinty to take her kids to school or by a ritzy California star. It should be used in environmentally sensitive areas,” Brown says.

Work also is underway to make biofuels from more exotic raw materials: algae, castor oil, coffee grinds, microbes, feather meal, salmon oil, tobacco, and other various grasses, seeds and trees. Hollywood stars publicize their use of biofuels made from restaurant greases left over from fast food frying. Such substances, though, have limited range because of their tendency to freeze, and can only be made available in small quantities.

Meanwhile, the aviation industry is moving into biofuels. Boeing, the Mexican Airports and Auxiliary Services Agency, and Honeywell have teamed up to find ways of using Mexican crops for biofuel. In the United States, the shipping company Fedex has pledged that a third of its fuel will come from bioenergy by 2030. Bioenergy also is being used in power production, mostly at small generating plants. One area of promise is the co-firing of bioenergy and coal. The power plant uses coal part of the time, keeping costs low, and bioenergy the remainder to improve the power plant’s environmental profile.

Worldwide demand for biofuel is projected to grow 8.6 percent annually through 2030. Achieving this depends on government support since biofuels, like most renewable energy sources, still rely on financial incentives. In the United States, for example, a federal standard mandates an increase in the biofuel mix in

хэрэглээгээ хязгаарлаж, биодизелийн хэрэглээгээ нэмэгдүүлэхийг уриалж байна. Энэ нь био түлшний үйлдвэрлэлийг дэмжихээс гадна тариан талбайг бензин, шатахуунаас ялгардаг хорт хаягдлаар бохирдуулахгүй байх сайн талтай. Гэвч хөдөө аж ахуйн салбар нь АНУ-ын үндэсний нийт бүтээгдэхүүний дөнгөж 1 хувийг эзэлдэг учраас хөдөө аж ахуйд био түлш хэрэглэснээр шатахууны хэрэглээг мэдэгдэхүйц хэмжээгээр бууруулж чадахгүй. Өөрөөр хэлбэл биодизель нь АНУ-ын нийт шатахууны хэрэгцээний өчүүхэн хэсгийг хангах боломжтой. Тийм ч учраас биодизелийг хүмүүсийн өдөр тутмын зориулалтаар ашиглахын оронд хүрээлэн буй орчинд хөнөөлтэй байж болох зарим салбарт л ашиглахыг Браун зөвлөж байна.

Эрдэмтэд замаг, чинжүү, кофены ургамал, нян, өдний нунтаг гурил, яргай загасны тос, тамхи зэрэг өвөрмөц түүхий эдийг ашиглан биодизель гарган авах туршилт хийж байна. Холливудын зарим одууд түргэн хоолны газрын хаягдал болох өөхөн тосноос гарган авсан био түлшийг ашигладаг гэж сурталчилж байна. Гэвч өөхөн тос зэрэг түүхий эд нь цаг агаар хүйтрэх тусам царцах магадлал ихтэй учраас био түлш үйлдвэрлэхэд төдийлөн тохиромжтой биш гэж үздэг.

Сүүлийн хэдэн жилийн хугацаанд агаарын тээврийн салбарт био түлшийг хэрэглэж эхэллээ. Жишээлбэл, Боинг, Ханивелл корпорациуд Мексикийн нисэх буудлууд болон Туслах үйлчилгээний агентлагтай хамтран Мексикийн нутаг дэвсгэрт тариалагдсан үр тарианаас био түлш гарган авах аргыг судалж байна. АНУ-ын Федекс компани 2030 он гэхэд нийт түлш шатахууныхаа хэрэглээний гуравны нэг хувийг био түлшээр хангах амлалт өгч байна. Био эрчим хүч нь жижиг оврын цахилгаан станцад ч гэсэн өргөн ашиглагдах болжээ. Цахилгаан станцууд био түлшийг нүүрстэй хамт хэрэглэх тухай асуудал ч яригдаж байна. Хэдийгээр цахилгаан станцууд нүүрсийг хямдхан учраас өргөн хэрэглэдэг ч гэсэн ойрын ирээдүйд био түлшийг өргөн хэрэглэснээр хүрээлэн буй орчимд цацагдах хорт хийн хэмжээг багасах ач холбогдолтой.

2030 он гэхэд дэлхийн хэмжээнд био түлшний 1 жилийн эрэлт 8.6 хувиар өсөх хандлага ажиглагдаж байна. Гэвч энэ зорилтыг бодит байдал болгох нь засгийн газрын дэмжлэг хэр байгаагаас шалтгаална. Учир нь био түлш

gasoline to almost 145 million kiloliters by 2022. In addition, the Obama administration has committed $80 million to advanced biofuels research.

Given this kind of support, coupled with the push for oil alternatives, bioenergy injects new vigor and livelihood to the very old business of farming. The agricultural industry, already responsible for products that create food, clothing, and material for shelter, is now firmly in the business of providing another necessity: the energy to make it all work.

The opinions expressed in this interview do not necessarily reflect the views or policies of the U.S. government.

зэрэг нөхөн сэргээгдэх эрчим хүчний бусад эх үүсвэрүүдийг боловсруулах судалгаа, төсөл нь их хэмжээний хөрөнгө шаарддаг. Жишээ нь АНУ-ын засгийн газар 2022 он гэхэд бензин, шатахууны найрлага дахь био түлшний хэмжээг 145 сая килолитр болгох зорилт тавин ажиллаж байгаа юм. Ерөнхийлөгч Обамагийн засаг захиргаа био түлшний судалгаанд зориулан 80 сая доллар зарцуулах амлалт өгсөн.

Засгийн газар газрын тосыг орлож чадах эрчим хүчний бусад эх үүсвэрт хөрөнгө оруулж, дэмжлэг үзүүлснээр био эрчим хүч нь хөдөө аж ахуйн салбарын хөгжилд шинэ түлхэц болох юм. Хүнс, хувцас, орон байрны хэрэгцээг хангаж байсан уламжлалт хөдөө аж ахуйн салбар нь орчин үед эрчим хүчний хэрэгцээг хангах гол эх үүсвэр болох магадлалтай юм.

Энэ ярилцлаганд дурьдагдсан мэдээлэл нь АНУ-ын засгийн газрын байр суурийг төлөөлөхгүй болохыг анхаарна уу.

International agricultural trade
Олон улсын зах зээл дэх хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний худалдаа

Some examples of the foodstuffs important to international trade
Олон улсын зах зээлд өргөн худалдаалагддаг хүнсний бүтээгдэхүүний төрлүүд

leading countnes in the export of major commodities indicated
Гол нэр төрлийн хүнсний бүтээгдэхүүний экспортоор дэлхийд тэргүүлдэг улс орнууд

Argentine/Аргентин	**Soybean oil/Хан боргоцой**	**Philippines/Филиппин**	**Bananas/Гадил**
Brazil /Бразил	**Chicken meat/ Тахианы мах**	**/Өмнөд Африк**	**south Oranges/Жүрж**
Canada/Канад	**Wheat/Улаан буудай**	**Spain/Испани**	**Olive oil/Оливын тос**
Costa Rica/Коста Рика	**Pineapples/Хан боргоцой**	**Tunisia/Түнис**	**Dates/Нанжин чавга**
France/Франц	**Wine/Дарс**	**Turkey/Турк**	**Dry apricots/Хатаасан чангаанз**
Malaysia/Малайз	**Palm oil/Дал модны тос**	**United States /АНУ**	**Maize/Эрдэнэ шиш**

Data Source. U.N. Food and Agriculture Organization illusration by Nicolle Rager Fuller

Agriculture in the Global Marketplace

C. Peter Timmer

Twenty-first-century agriculture is likely to build stronger links between farmers in rural areas and city dwellers in order to create market systems with greater efficiency and better technologies.

C. Peter Timmer is a leading economist in the fields of agricultural and development economics. He has held professorships at Stanford, Cornell, and the University of California, San Diego. He is currently the Thomas D. Cabot Professor of Development Studies, emeritus, Harvard University.

The increasing globalization of agriculture and the resulting dominant role of supermarkets benefit many but harm others. Those who influence the 21st-century global marketplace should seek to allocate its burdens equitably, while preserving the real gains that afford millions a greater variety of healthful, more affordable sustenance.

By its very nature, agriculture is mostly a local activity, its roots in the soil. Most of the world's billion or more farmers live within walking distance of the crops they grow and eat. The co-evolution of human societies and cultivated species has led to superb adaptation to specific environments, and has created highly diversified cropping systems that can meet the wide nutritional needs of household members. Localized agriculture is still the norm for the vast majority of the world's poor people.

Economists have long viewed this dependence as a cause of poverty, not a historical accident. Agriculture limited to indigenous crops, locally available soil nutrients, and household labor, they argue, is a recipe for poverty and malnutrition. Local food self-sufficiency, they conclude, impoverishes individual households and the overall economy. Two Nobel Prizes in Economics were awarded in 1979 for these

Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн дэлхийн зах зээлд

С. Питер Тиммер

21-р зууны хөдөө аж ахуйн салбар нь хөдөөгийн фермерүүд болон хотын оршин суугчдын хооронд харилцаа тогтоох гол хэрэгсэл болжээ. Энэ холбоог хангах гол талбар нь зах зээлийн шинэ технологи юм.

С. Питер Тиммер бол хөдөө аж ахуй болон хөгжлийн эдийн засгийн чиглэлээр судалгаа явуулдаг тэргүүлэх эдийн засагч нарын нэг юм. Профессор Тиммер Станфордын Их сургууль, Корнеллийн Их сургууль, Сан Диего дахь Калифорнийн Их сургууль зэрэг шилдэг сургуулиудад багшилж байсан. Тэрээр одоо Харвардын Их сургуульд багшилж байна.

Хөдөө аж ахуйн салбар улам даяарчлагдсанаар хот суурин газрын их дэлгүүрүүд зах зээлд ноёлох байр суурьтай болж байна. Ялангуяа, 21-р зууны дэлхийн зах зээлд ноёрхож буй салбарууд нь үүрэг хариуцлагаа тэгш хуваарилах шаардлага тулгарч байгаа юм. Хамгийн гол нь хөдөө аж ахуйн салбар даяарчлагдсанаар дэлхийн олон сая хэрэглэгчид төрөл бүрийн чанартай, эрүүл хүнс хэрэглэх боломж нээгдэж байна.

Хөдөө аж ахуй нь өөрийн онцлогоос хамаарч ихэвчлэн хөдөөгийн буюу орон нутгийн бизнес гэж тооцогддог. Гэвч фермерүүд болон дэлхийн хэдэн тэрбум хэрэглэгчдийн хоорондын зай тийм ч хол биш. Өөрөөр хэлбэл хэрэглэгч болон ургацын талбай хоорондын зайг бараг явган явчих хэмжээний зай гэж тодорхойлж болно. Хүний нийгмийн хөгжлийг дагаад хөдөө аж ахуйн технологи хүртэл нарийн хөгжсөн. Орчин үед төрөл бүрийн орчинд ургах чадвартай шинэ төрлийн ургац гарч байна. Түүнчлэн ургац тариалалтын арга технологи ч гэсэн боловсронгуй болсны ачаар хүнсний бүтээгдэхүүний илчлэг улам нэмэгдэж байна. Гэвч хөдөө ахуй нь дэлхийн хамгийн ядуу буурай хүмүүсийн эрхэлдэг бизнес хэвээр байгаа юм.

Зарим эдийн засагчид энэ хамаарлыг түүхэн үйл явцын үр дүн биш, харин ядууралтай холбон

insights: to T.W. Schultz for emphasizing the need for new technologies to overcome rural household poverty, and to W. Arthur Lewis, for his emphasis on the role of agricultural modernization as a crucial input to overall economic development.

Globalized Markets

Market interactions between farm and urban households are the key to solving both problems. However, markets bring not just access to better technology and greater efficiency, they also bring new risks — that price fluctuations may offset

A shopper chooses from a selection of imported foods at a Shanghai supermarket. Food imports to China are increasing, like many products from abroad.

© AP Images/Feng lei sh/Imaginechina

Шанхай хотын нэгэн их дэлгүүрт худалдаалагдаж буй төрөл бүрийн импортын бүтээгдэхүүнээс худалдан авагч сонголт хийж байна. Хятадын зах зээлд нийлүүлэгдэж буй импортын хүнсний бүтээгдэхүүний хэмжээ огцом нэмэгдэж байгаа юм.

тайлбарладаг. Өөрөөр хэлбэл хөдөө аж ахуй нь тодорхой хэсэг газар, нутгийн хөрсний үржил шим, өрхийн хөдөлмөрөөс шууд хамааралтай байдаг учраас ядуурал, хоол тэжээлийн дутагдал гэдэг сөрөг үр дагавар зайлшгүй гарч ирдэг. Тухайлбал, хөдөөгийн хүн амын дийлэнхи нь зөвхөн өөрсдийнхөө хүнсний хэрэгцээг хангах байдлаар хязгаарлагддаг учраас энэ нь тухайн өрхийн орлого болон нийт эдийн засагт сөрөг нөлөө үзүүлдэг. 1979 онд эдийн засгийн салбарт Нобелийн шагнал хүртсэн 2 эрдэмтэн чухам ийм таамаглал дэвшүүлж байсан нь бодит байдал дээр нотлогдож байна. Эрдэмтэн Т.В.Шульц хөдөөгийн иргэдийг ядуурлаас гаргах гол арга зам бол шинэ технологи гэж үзсэн бол В.Артур Люисс хөдөө аж ахуйн салбарт технологийн хувьсгал хийснээр нийт эдийн засгийн хөгжилд ч хувь нэмэр оруулна гэж үзэж байлаа.

Даяарчлагдсан зах зээл

Хөдөөгийн фермийг хотын хэрэглэгчидтэй холбох гол хэрэгсэл нь зах зээл бөгөөд хөдөө аж ахуйг зах зээлтэй холбосноор ядуурлын

farmers' hard work and leave them in debt. At the same time, dynamic urban economies offer farmers, and especially their children, the chance for a new life in the city. Expand markets to a global scale, and the opportunities, choices, and risks at the farm and national levels all multiply.

The globalization of markets is not new. Those of us who live in the United States have relied on global markets for centuries — they supply our coffee, tea, and spices, for example, and buy our surplus grain, tobacco, and vegetable oils. Other parts of the world have been connected similarly since the beginning

A shopper chooses from a selection of imported foods at a Shanghai supermarket. Food imports to China are increasing, like many products from abroad.

© AP Images/Hasan Jamali

Саудын Арабын фермерүүд нанжин чавгаа Рияд хотын захад байрлах хүнсний зах дээр худалдаалдаг. НҮБ-ын Хүнс хөдөө аж ахуйн байгууллагын тайланд дурьдсанаар Саудын Араб нь нанжин чавганы үйлдвэрлэлээрээ Египет, Иран улсуудын дараа гуравдугаар байранд ордог ажээ.

асуудлыг шийдвэрлэх боломжтой. Гэвч зах зээл нь зөвхөн шинэ технологи олж авах, үр өгөөжийг дээшлүүлэх боломж олгохоос гадна зарим сөрөг үр дагаварыг агуулдаг. Жишээ нь үнийн хэлбэлзэл нь фермерүүдийн шургуу хөдөлмөрийн үр шимийг баллаж, өрөнд оруулах ч тохиолдол бий. Нөгөө талаар хотын эдийн засгийн уян хатан шинж чанар нь фермерүүдийн үр хүүхдүүдэд хот суурин газарт шилжин суурьших шинэ гарц нээж байгааг үгүйсгэх аргагүй. Мэдээж хэрэг хөдөө аж ахуйн салбар улам даяарчлагдсанаар шинэ боломж, шинэ сонголтуудыг бий болгохоос гадна шинэ шинэ эрсдлийг ч төрүүлдэг нь тодорхой.

Зах зээлийн даяарчлал нь цоо шинэ үзэгдэл биш. Жишээлбэл, АНУ-ын иргэд хэдэн зууны турш дэлхийн зах зээлээс хараат байсаар ирсэн. Америкчууд кофе, цай, халуун ногоогоо гаднаас худалдан авдаг бол дэлхийн бусад ард түмнүүд

of modern economic growth. Wheat prices in 18th-century England were tied directly to prices in the Baltic ports; rice prices in Calcutta and Bombay, even Paris, were linked to prices in Rangoon and Saigon. Long-distance trade in agricultural commodities benefits people on both ends of the transaction.

Still, the modern round of globalization is broader and deeper than anything seen in the 18th or 19th

This farmer's market in San Francisco gives local growers an outlet to sell their produce directly to consumers in competition with supermarkets.

© AP Images/Eric Risberg

Сан Франциско хотын захад байрладаг хүнсний зах нь орон нутгийн фермерүүдийн хувьд бүтээгдэхүүнээ хэрэглэгчдэд шууд хүргэх боломж олгодог. Мэдээж хэрэг фермерүүдийн гол өрсөлдөгч нь хүнсний дэлгүүрүүд юм.

бидний үр тариа, тамхи, ургамлын тосыг худалдан авдаг. Орчин үеийн эдийн засгийн харилцаа үүссэн тэр цагаас эхлэн дэлхийн ард түмнүүд хоорондоо нягт холбогдсон гэж хэлж болох юм. Жишээ нь 18-р зууны үед Англи улсад тариалагдсан улаан буудайны үнэ нь Балтийн тэнгисийн эрэгт орших боомтуудын ханш, Калькутта, Бомбэйд тариалсан цагаан будааны үнэтэй харилцан хамааралтай байжээ. Парис хотын зах дээр худалдаалагддаг хүнсний бүтээгдэхүүн ч гэсэн Рангун, Сайгоны захын үнэтэй хамааралтай байлаа. Тухайн үед хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнийг асар хол зайд тээвэрлэдэг байсан ч гэсэн аль аль талдаа ашигтай бизнес байсан юм.

Харин 18-19-р зууны үетэй харьцуулахад орчин үеийн даяаршил нь хамрах хүрээгээрээ хавьгүй өргөн юм. Хүнсний бүтээгдэхүүний зах зээлийг даяарчлагдахад нөлөөлсөн 3 хувьсгал бий. Үүнд:

- Хөдөө аж ахуйн технологийн салбарт хувьсгал гарснаар бүтээгдэхүүний үр ашиг дээшилснээс гадна хөдөө аж ахуйд төрөл бүрийн технологи нэвтэрсэн;

centuries. Three revolutions have stimulated the rapid integration of commodity markets:

- The revolution in agricultural technologies that permits highly productive but specialized farming techniques;
- The revolution in communications and transportation that permits buyers and sellers to connect quickly and at low cost across vast distances;
- The revolution in global living standards that has brought billions of new consumers into a world of discretionary purchases.

Modern globalization is the result of progress in supply, marketing, and demand.

Driven by these forces, agricultural globalization shapes the diet of consumers and the practices of farm producers. The former benefit from the ready and affordable availability of more diversified foodstuffs, a cornucopia far beyond what domestic agricultural production can provide. European consumers have daily access to fresh green beans from Kenya; American consumers enjoy fresh Peruvian asparagus in February. Low-cost transportation systems and falling trade barriers offer many consumers a market basket that draws from the entire world's bounty and diversity.

At the same time, globalization can incentivize individual famers to specialize in a single crop even as national agricultural sectors on balance may grow more diversified. Unless agro-ecological conditions are nearly identical throughout a country, farmers will — for reasons of resources, soil quality, or a number of other factors — develop a competitive advantage in growing a particular kind of crop. They utilize their farm resources most efficiently by specializing in growing that crop. This narrow specialization is consistent with greater diversity at the national level because of the commercialization of agriculture and international trade in food commodities.

The Role of Supermarkets

Modern supermarkets afford consumers the bounty of an international marketplace. By focusing the purchasing power of billions of consumers, they can

- Харилцаа холбоо болон зам тээврийн салбарт хувьсгал хийгдсэнээр үйлдвэрлэгчид болон хэрэглэгчид хоорондоо хямд зардлаар, хурдан холбогдох боломжтой болсон;
- Дэлхийн хүн амын амьжиргааны түвшин дээшилж, амьдралын хэв маяг өөрчлөгдсөнөөр хэрэглэгч, худалдан авагчдын тоо огцом нэмэгдсэн.

Орчин үеийн даяаршил нь хангалт, эрэлт хэрэгцээ болон маркетингийн харилцан хамаарлын үр дүн юм.

Тийм ч учраас хөдөө аж ахуйн даяаршил нь хэрэглэгчдийн хоол хүнс болон фермерүүдийн үйл ажиллагааг шууд тодорхойлж байна. Хэрэглэгчид маш олон төрлийн хүнсний бүтээгдэхүүнээс сонголт хийж бололцоотой болжээ. Харин улам бүр өсөн нэмэгдэж буй эрэлт хэрэгцээг зөвхөн дотоодын фермүүд хангах бололцоогүй юм. Тийм ч учраас Европын хэрэглэгчид Кени улсаас өдөр бүр шинэхэн ногоон буурцаг худалдан авдаг бол, Америкийн хэрэглэгчид 2-р сард Перугийн шинэхэн аспарагусыг хэрэглэдэг. Тээвэрлэлтийн хөлс хямд, зах зээл улам нээлттэй болж байгаа учраас хэрэглэгчид дэлхийн өнцөг булан бүрт үйлдвэрлэгдсэн төрөл бүрийн хүнсний бүтээгдэхүүнийг хэрэглэх боломжтой болсон.

Хөдөө аж ахуйн салбар улам даяарчлагдахын хэрээр фермерүүд нэг төрлийн ургац буюу бүтээгдэхүүнийг дагнан үйлдвэрлэх хандлагатай болжээ. Харин үндэсний хэмжээнд ургацын төрөл зүйл харьцангуй олон болсон. Хэдийгээр агро-экологийн нөхцөл харьцангуй ойролцоо ч гэсэн хөрсний чанар болон бусад хүчин зүйлсийн нөлөөгөөр зарим фермерүүд зөвхөн тодорхой төрөл зүйлийн ургацыг дагнан тариалах болжээ. Өөрөөр хэлбэл дагнан төрөлжсөнөөр тухайн фермийн нөөцийг улам илүү үр ашигтай ашиглах боломж нээгдэнэ гэсэн үг. Тодорхой нэг фермийн хувьд ургацаа дагнан тариалж байгаа ч гэсэн олон улсын худалдааны эрчимтэй хөгжлийн ачаар үндэсний хэмжээнд ургацын нэр төрөл олширч байна.

Их дэлгүүрүүдийн үүрэг оролцоо

Орчин үеийн их дэлгүүрүүд нь олон улсын зах зээлийн ашиг тусыг хэрэглэгчдэд мэдрүүлдэг гол газар болжээ. Их дэлгүүрүүд нь хэдэн тэрбум хэрэглэгчдийн эрэлт хэрэгцээг хангах зорилготой учраас олон төрлийн бараа бүтээгдэхүүнийг хямд үнээр санал болгож байна. Гэвч их дэлгүүрүүдийн сүлжээ улам өргөжсөнөөр фермийн үйл ажиллагаанд ч гэсэн тодорхой дарамт учруулдаг. Өөрөөр хэлбэл эрэлт нийлүүлэлтийн тэнцвэрийг хангахын тулд үр дүнтэй менежмент хэрэгтэй гэсэн үг. Фермийн бүтээгдэхүүний төрөл, бүтээгдэхүүний үнэ үндэслэлтэй, хэрэглэгчдийн худалдан авах чадварт тохирсон байх ёстой.

offer a wide variety of appealing foods at low prices. But supermarkets also amplify the globalization-driven pressure upon the farm sector to adopt efficient supply-chain management practices. The impact on the structure of farm production, on who participates in the marketing process, and on the nature and cost of products available to consumers is profound.

Supermarkets and the transnational corporations (TNCs) that commonly own them also face fierce competition. TNCs such as Wal-Mart in the United States, Tesco in the United Kingdom, Carrefour in France, and Ahold in the Netherlands try to escape the resulting squeeze on profits by applying new information technologies to lower supply-chain costs and by fleeing the home market and moving into countries where food retailing remains comparatively inefficient and profit margins high. Most transnational corporations engaged in food marketing have done both.

TNC-owned supermarkets increasingly dominate the global food supply chain. Backed by foreign direct investment, TNCs consolidate the food retailing industry in many countries and, some allege, extract high, even monopoly profits. But what does this mean for consumers? The answer is complicated.

Technology that lowers transaction costs throughout the food supply chain can enhance supermarket profits even as customers reap the benefit of lower prices. Increasingly, information technology affords supermarket managers exquisite control over procurement, inventory levels, and knowledge of consumer checkout profiles. This translates into powerful competitive advantages in cost control, quality maintenance, and product tracking in case of defects or safety problems.

Globalized agriculture affords a number of other benefits. If Florida, for instance, experiences a killing frost, American consumers do not lack for orange juice; Brazilian and other substitutes are readily available in the United States, and vice versa. Global production boosts global food security, and affords a partial insurance policy against the impact of climate change on crop production.

But as the cost of information technology drops, determining the beneficiaries becomes less clear. As more competitors adopt the latest technology, competition among food retailers intensifies. The resulting low prices benefit consumers. The TNCs

Их дэлгүүрүүд болон үндэстэн дамнасан корпорациуд ч гэсэн дэлхийн зах зээл дээр ширүүн өрсөлддөг. Жишээ нь АНУ-ын Уол-Март, Их Британийн Теско, Францын Каррефор, Нидерландын Ахолд корпорациуд ашгаа нэмэгдүүлэх зорилгоор эрэлт-нийлүүлэлтийн өртгийг бууруулах шинэ технологи нэвтрүүлж байгаагаас гадна зөвхөн дотоодын зах зээлээр хязгаарлагдалгүйгээр жижиглэн худалдаа хөгжөөгүй бусад улс орнуудад салбараа нээж ашиг олох эрмэлзэлтэй болжээ. Үндэстэн дамнасан корпорациудын зах зээл нь дотоодын зах зээлээс гадна гадаад улс орнууд болсон. Өөрөөр хэлбэл үндэстэн дамнасан корпорациудын эзэмшдэг хүнсний их дэлгүүрүүдийн сүлжээ нь дэлхийн хүнсний нийлүүлэлтийн сүлжээг бүрэн хянаж байна. Гадаадын шууд хөрөнгө оруулалтын тусламжтайгаар үндэстэн дамнасан корпорациуд дэлхийн олон улс оронд жижиглэн худалдааны салбарт ноёрхлоо тогтоожээ. Зарим нь бүр монополь тогтоосон гэж шүүмжлэгдэж байна. Хэрэглэгчдэд энэ нь ямар нөлөө үзүүлэх вэ гэсэн асуулт гарч ирнэ. Энэ асуултанд хариулахад нэлээд төвөгтэй. Нэг талаар технологи нь хүнсний бүтээгдэхүүнийг тээвэрлэх, нийлүүлэх өртгийг багасгаж, их дэлгүүрүүдийн ашгийг нэмэгдүүлэхэд тус болж байгаагаас гадна хэрэглэгчид ч гэсэн хямд үнэтэй бүтээгдэхүүн худалдан авах боломжтой. Мэдээллийн технологийн хөгжил нь их дэлгүүрийн эздэд бараа бүтээгдэхүүний нийлүүлэлт, орлого, зарлага, хэрэглэгчдийн худалдан авсан зүйлсийг хүртэл хянах бололцоо олгож байна. Өөрөөр хэлбэл мэдээллийн технологийн тусламжтайгаар дэлгүүрийн үр ашиг, барааны чанар, бүтээгдэхүүнээ хянах боломжтой болжээ.

Хөдөө аж ахуйн салбар даяарчлагдсан нь олон давуу талтай. Флорида мужид цочир хүйтэрсэн ч гэсэн Америкийн хэрэглэгчид сайн чанарын жүржийн шүүсээр дутагдахгүй. Учир нь Бразил зэрэг хэд хэдэн улсад үйлдвэрлэгдсэн жүржийн шүүсийг Америкийн их дэлгүүрүүдээс худалдан авах боломжтой. Дэлхийн хэмжээнд хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл огцом нэмэгдсэнээр хүнсний аюулгүй байдлыг хангах асуудал ч давхар сөхөгдөнө. Уур амьсгалын өөрчлөлт ургацын гарцанд нөлөөлдөгийг харгалзан үзэж, даатгалын үр ашигтай бодлого явуулах ч шаардлага тулгарч байна.

Мэдээллийн технологийн үнэ өртөг буурснаар ямар ашиг олж байгааг тооцоолоход хэцүү. Өрсөлдөгч үйлдвэрүүд хамгийн сүүлийн үеийн мэдээллийн технологийг өргөн ашигладаг болсон учраас жижиглэн худалдаа эрхлэгчдийн дунд ширүүн өрсөлдөөн өрнөж байна. Улмаар ширүүн өрсөлдөөний үр дүнд бүтээгдэхүүний үнэ буурдаг учраас хэрэглэгчдэд ашигтай байдаг. Түүнчлэн үндэстэн дамнасан корпорациуд ч гэсэн энэ ханган нийлүүлэгчидтэй байгуулсан гэрээнээс ашиг олох боломжтой. Өөрөөр хэлбэл их дэлгүүрт зарагдаж

in turn require ever-greater efficiency from their suppliers. The constant pressure to lower costs in the food aisle ultimately is transferred all the way back to the individual farmer.

Concerns about Equity

The increasing dominance of supermarkets generates real concerns about fairness and equity in the agricultural marketing system. As many transactions shift from open and transparent public markets to supermarket procurement officers representing a few large buyers, food producers are more easily excluded from the negotiations. Prices are squeezed ever lower. Farmers adapt, or they are pushed out of farming.

But there is another side to this story. In a competitive environment, supermarkets must respond to customer preference. Some consumers care deeply about the environment. Others willingly pay somewhat higher prices to better sustain local farmers. TNCs manage some procurement contracts with these concerns in mind. Fears that a given TNC will establish monopoly control and market power in the developing world appear overstated: The success of one supermarket chain attracts others. The TNCs compete, fiercely, among themselves. The market for the food consumer's dollar seems to be highly contestable, even when only a small handful of retailers survive the cost competition.

Unquestionably, the growth of the TNC-owned supermarket poses risks to small farmers. Because of the high transactions costs, working with large numbers of small farmers is more expensive than doing business with a few large suppliers. Small famers easily can lose access to supermarket supply chains, and fall further into poverty. But with risk often comes opportunity. Some small farmers have gained profitable access to modern supply chains. Small farmers in Central Java, Indonesia, now sell their specialized "black watermelons" not just to local consumers, but to consumers in Jakarta, Singapore and Kuala Lumpur as well. Poor countries that successfully integrate some small farmers into the supermarket supply chain will benefit greatly.

байгаа хүнсний бүтээгдэхүүний үнэ хямдрах тусам түүхий эдийг хямдхан авах шаардлага тулгардаг учраас фермерүүд үнээ буулгахаас өөр аргагүй болно.

Тэгш байдлыг хэрхэн хангах вэ?

Хүнсний бүтээгдэхүүний зах зээлд их дэлгүүрүүдийн сүлжээ ноёлох үүрэг гүйцэтгэх болсонтой холбоотойгоор зах зээлийн шударга өрсөлдөөн, тэгш байдлыг хэрхэн хангах вэ гэдэг асуудал зайлшгүй сөхөгдөнө. Ялангуяа, хүнсний дэлгүүрүүдийн хангамжийн бараа хариуцсан менежерүүд зөвхөн цөөн тооны томоохон худалдан авагч нарыг төлөөлдөг учраас жирийн фермерүүд яриа хэлэлцээнд оролцох магадлал багатай байдаг. Өөрөөр хэлбэл худалдан авагч нар өөрсдийн эрх ашгийг хангахын тулд хамгийн бага үнийг санал болгодог байна. Фермерүүд нэг бол хямд үнийн саналыг хүлээх зөвшөөрөх эсвэл бизнесээ орхиход хүрдэг.

Гэвч энэ асуудлыг өөр талаас нь ч тайлбарлаж болно. Зах зээлийн өрсөлдөөн улам ширүүсч байгаа өнөө үед их дэлгүүрүүд зөвхөн хэрэглэгчдийнхээ эрэлт хэрэгцээг хангахын төлөө өрсөлддөг. Тийм ч учраас зарим худалдан авагч нар хүрээлэн буй орчинд хор хөнөөлгүй бүтээгдэхүүнд илүү талтай хандаж эхэлсэн бол зарим нь хөдөөгийн фермүүдийн үйл ажиллагааны тогтвортой байдлыг хангахын тулд илүү өндөр үнэ төлөхийг зөвшөөрдөг болжээ. Үндэстэн дамнасан корпорациуд ч гэсэн фермерүүдтэй аль болох ойлголцож, хамтран ажиллахыг хичээдэг болсон нь сайшаалтай. Тийм ч учраас үндэстэн дамнасан корпорациуд хүнсний бүтээгдэхүүний салбарт монополь тогтоосон гэж тодорхойлох нь зарим талаар учир дутагдалтай. Учир нь үндэстэн дамнасан корпорациуд ч гэсэн зах зээл дэх байр суурьиа алдахгүйн тулд хоорондоо ширүүн өрсөлдөг байна. Ийм өрсөлдөөний хамгийн тод жишээ бол үнийн өрсөлдөөн юм. Үнийн өрсөлдөөнд ялагдах нь томоохон их дэлгүүрүүдийн сүлжээнд үхлийн эрсдэл учруулдаг бол жижиглэн худалдаачдад харьцангуй аюул багатай.

Мэдээж хэрэг үндэстэн дамнасан корпорациудын хяналтанд байдаг их дэлгүүрүүдийн сүлжээ нь жижиг фермерүүдийн үйл ажиллагаанд эрсдэл учруулж болно. Учир нь тээвэрлэлтийн зардал өндөр байдаг учраас их дэлгүүрүүд олон тооны жижиг фермүүдтэй хамтран ажиллахын оронд цөөн тооны томоохон фермүүдээс бараа татах сонирхолтой байдаг юм. Өөрөөр хэлбэл жижиг фермүүд аажимдаа зах зээлээс шахагдаж, эзэд нь дампуурах эрсдэлтэй. Гэвч зарим тохиолдолд эрсдэл ч гэсэн боломж бололцоог давхар агуулж байдаг. Жишээ нь зарим жижиг фермүүд ухаалаг оновчтой менежмент хийсний үр дүнд томоохон

Globalized food supply chains are a two-edged sword. They afford consumers lower prices and greater food security. But countries can lose control of their own food production and trade, as foreign consumers and producers drive local prices. A new international trade regime must balance equitably these positives and negatives, especially so that the poorest countries — the least food secure — do not suffer.

The opinions expressed in this article do not necessarily reflect the views or policies of the U.S. government.

Top Crop Producers
Ургацын үйлдвэрлэлээр дэлхийд тэргүүлдэг улс орнууд

The nations that lead the world in producing various crops of interest are noted below, according to the latest data available from the U.N. Food and Agriculture Organization from the 2007 harvest.

Энэ хүснэгтэнд ургацын төрөл бүрээр дэлхийд тэргүүлдэг улс орнуудыг үзүүлэв. Мэдээллийг НҮБ-ын Хүнс хөдөө аж ахуйн байгууллагын 2007 оны тайлангаас авлаа.

Nation/ Улсын нэр	Crop/ Ургацын төрөл	Yield/ Ургацын хэмжээ
China/ Хятад	Rice/Цагаан будаа	187 million metric tons/187 сая тонн
China/Хятад	Wheat / Улаан буудай	109 million metric tons/109 сая тонн
United States/АНУ	Maize/Эрдэнэ шиш	330 million metric tons/330 сая тонн
France/Франц	Barley/Арвай	9.5 million metric tons/9.5 сая тонн
Nigeria/Нигери	Cassava/Кассава	43 million metric tons/43 сая тонн
Brazil/Бразил	Sugarcane/Чихрийн нишингэ	550 million metric tons/550 сая тонн

их дэлгүүрүүдтэй хамтран, ашигтай ажиллаж байна. Тухайлбал, Индонезийн Ява арлын жижиг фермерүүд хар тарвасаа зөвхөн нийслэл Жакарта хотоос гадна Сингапур, Малайзын Куала Лумпур хотын их дэлгүүрүүдэд худалдаалж байгаа юм. Зарим хөгжиж буй орнууд жижиг фермүүдийг их дэлгүүрийн сүлжээтэй холбож чадсанаар их ашиг олж байна.

Даяарчлагдсан хүнсний хангамжийн сүлжээг хоёр иртэй сэлэм гэж тодорхойлж болох юм. Их дэлгүүрүүд нь нэг талаас хэрэглэгчдээ алдахгүйн тулд аль болох хямд үнээр их бүтээгдэхүүн нийлүүлэхийг эрмэлздэг. Нөгөө талаар гадаадын хэрэглэгчид болон үйлдвэрлэгч нар тухайн улсад үйлдвэрлэгдсэн хүнсний бүтээгдэхүүний үнийг тогтоох хандлагатай байдаг нь сөрөг тал юм. Тийм ч учраас олон улсын хэмжээнд хүнсний худалдааны тэгш байдал, шударга өрсөлдөөнийг хангах тусгай журам зохицуулалт хийх шаардлага тулгарч байгаа юм.

Энэ бүлэгт дурьдагдсан санаа нь АНУ-ын засгийн газрын бодлого, албан ёсны байр суурийг төлөөлөхгүй болно.

Nature + Science = New Crops

About 6,000 years ago, according to archaeological evidence, prehistoric farmers in the Americas cross-bred corn plants to create a crop with desirable traits that originally occurred in only a few plants. Centuries later, a 19th-century Austrian priest, Gregor Johann Mendel, experimented with tens of thousands of pea plants and identified the laws of cross breeding plants. The significance of his work was only properly recognized in the early 20th century when Mendel's Laws of Inheritance became a touchstone for the new science of genetics.

Today, most of the world's major food crops are grown from hybrid strains. Genetic science has advanced with the emergence of biotechnology and the creation of genetically modified organisms (GMOs). Though these technologies have been controversial, and adamantly opposed by some, many respected scientists assert that developing plants genetically capable of producing greater yields with less fertilizer and water is necessary to meet the food needs of the future.

Regardless of how the controversy over genetic engineering is resolved, there is no question that humans have a long history in the manipulation of plant species, resulting in greater abundance and variety in the modern diet.

Байгаль + Шинжлэх ухаан = Шинэ ургац

Бараг 6,000 жилийн өмнө Америк тивийн нутаг дэвсгэрт амьдарч байсан хүмүүс хэд хэдэн төрлийн ургацыг ашиглан шинэ төрлийн чанарлаг ургац гарган авч тариалж байсныг археологийн судалгаа нотолж байна. Хожим 19-р зуунд Австрийн нэрт шашны зүтгэлтэн, эрдэмтэн Грегор Йоханн Мендел вандуйны хэд хэдэн төрлийг судалж, улмаар ургамлын төрөл зүйлийг үржүүлэх, эрлийзжүүлэх хуулийг нээж байжээ. Менделийн Удамшлын хуулийг 20-р зуунд бүрэн утгаар нь хүлээн зөвшөөрсөн бөгөөд түүний судалгааны бүтээлүүд нь орчин үеийн генетикийн шинжлэх ухааны эх үндэс болсон юм.

Өнөөдөр дэлхийн хэмжээнд тариалагдаж буй нийт ургацын дийлэнхи төрлийг нь эрлийзжүүлэх аргаар гаргаж авсан гэдгийг хэлэх нь зүйтэй. Ялангуяа, биотехнологийн салбар эрчимтэй хөгжсөнөөр генетикийн шинжлэх ухаанд дэвшил гарч, генетикийн аргаар амьд организм гарган авдаг болжээ. Хэдийгээр генетикийн технологийг зарим хүмүүс хурцаар шүүмжилдэг ч гэсэн ирээдүйн хүн төрөлхтний хүнсний хэрэгцээг хангах гол эх үүсвэр генетикийн аргаар гаргаж авсан ургац байх нь тодорхой байна. Тухайлбал, өтөг бордоо, ус бага шаарддаг шинэ төрлийн ургац гаргаж авах шаардлага тулгарч байна.

Хэдийгээр орчин үеийн генетикийн шинжлэх ухааныг шүүмжлэх хүн олон байгаа ч гэсэн хүн төрөлхтөн эрт дээр үеэс ургамлын төрөл зүйлүүдийг хооронд нь эрлийзжүүлж, ургацын чанарыг сайжруулсаар ирснийг өнөөгийн бидний хэрэглэж буй хүнсний бүтээгдэхүүнүүд харуулж байгаа юм.

Nature + Science

Байгаль + Шинжлэх ухаан

Courtesy of Stephen Ausmus/USDA

All of the food types included in this edible still life have been produced through genetic engineering, the process of inserting genes from one organism into another, giving the second plant a desirable quality of the first. The U.S. Department of Agriculture (USDA) reports the process is being used or tested on an increasing array of crops.

Энэ зурагт харуулсан олон төрлийн хүнсний ногоо, жимс жимсгэнийг генетик инженерийн аргаар гаргаж авсан юм. Тухайн нэг төрлийн ургацын генийг ашиглан гаргаж авсан хоёрдогч бүтээгдэхүүн нь эхний бүтээгдэхүүнээс илүү чанартай байдаг. АНУ-ын Хөдөө аж ахуйн яамны мэдээлснээр шинээр олон төрлийн ургацыг генетикийн аргаар гарган авч байна.

© AP Images/Desikan Krishnan

Pearl millet is a staple crop for people in the semi-arid tropics. The plants in this field in southern India have been genetically engineered to resist diseases that can kill an entire crop.

Хар будаа нь хуурай уур амьсгалтай бүс нутагт оршин суудаг хүмүүсийн үндсэн хүнс юм. Энэтхэгийн өмнөд нутагт тариалдаг генетикийн инженерчлэлийн аргаар гаргаж авсан хар будаа нь хүнсний ногоонд тохиолддог төрөл бүрийн өвчнийг эсэргүүцэх чадвартай болжээ.

Nature + Science

Байгаль + Шинжлэх ухаан

© AP Images/The Winchester Star/Scott Mason

